



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 25
№10 (1355)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠯᠠᠭ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

56.	Журам батлах тухай	Дугаар 142	403
57.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 161	417
58.	Үзэл баримтлал батлах тухай	Дугаар 176	429
59.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 181	461
60.	Журам батлах тухай	Дугаар 222	487



ТЭГШ	
304	Хүмүүжил
ТЭГШ	
305	Хүмүүжил
306	Хүмүүжил
307	Хүмүүжил
308	Хүмүүжил
309	Хүмүүжил



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 03-ны өдөр

Дугаар 142

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 18.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт тус тус даалгасугай.

3.Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд боомтуудын нэвтрэх чадварыг нэмэгдүүлж, зам тээвэр, аялал жуулчлалын дэд бүтэц, тоног төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, холбогдох аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Б.БАТ-ЭРДЭНЭ

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр
сарын 03-ны өдрийн 142 дугаар
тогтоолын хавсралт

**ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт зохион байгуулагдах аялал жуулчлалын үйл ажиллагаанд Аялал жуулчлалын тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг мөрдөнө.

1.3.Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад Монгол Улсын олон улсын гэрээнд энэ журмаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

1.4.Монгол Улсын хилийн тухай хуулийн 28.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас хилийн боомтыг түр хаах, түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг зогсоосон тохиолдолд хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулахгүй.

**Хоёр.Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг
зохион байгуулах**

2.1.Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйл ажиллагааг Аялал жуулчлалын тухай хуулийн 18.2-т заасны дагуу хууль зүйн болон аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан маршрутын дагуу зохион байгуулна.

2.2.Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагаанд бүлэг жуулчид (8 буюу түүнээс дээш) хамрагдана.

2.3.Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэх дотоодын аж ахуйн нэгж нь Аялал жуулчлалын тухай хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангасан, Улсын хил хамгаалах байгууллагатай “Улсын хилийн зурвас, бүсэд мөрдөх журам сахиулах гэрээ” байгуулсан тур оператор байна.



2.4. Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тур оператор нь Улсын хил хамгаалах байгууллага болон бүлэг жуулчдыг дараах мэдээллээр хангаж ажиллана:

2.4.1. бүлэг жуулчдын хил нэвтрэх боомт болон аяллын маршрутын мэдээлэл;

2.4.2. бүлэг жуулчдын хоноглох байршуулах хэрэгслийн мэдээлэл;

2.4.3. бүлэг жуулчдыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл, түүний аюулгүй байдал, бүрэн байдлын талаарх мэдээлэл;

2.4.4. аяллыг хөтлөн явуулах жуулчны хөтөч-тайлбарлагч болон жолоочийн мэдээлэл;

2.4.5. аяллын даатгалын мэдээлэл.

2.5. Энэ журмын 2.4.1-2.4.5-д заасан мэдээлэл, түүний захиалга, баталгаажуулалтыг Монгол Улсын тур оператор бүрэн хариуцаж зохион байгуулна.

2.6. Тур оператор нь жуулчдын Монгол Улсын хил нэвтэрснээс хойш эргэн хилээр гарах хүртэлх аюулгүй байдлыг хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд тухайн орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллана.

Гурав. Хил нэвтрэхэд бүрдүүлэх баримт бичиг

3.1. Монгол Улсын хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрийн үйл ажиллагаанд хамрагдах бүлэг жуулчид, жуулчны хөтөч-тайлбарлагч, жолооч нар дараах баримт бичгээр Монгол Улсын хил нэвтрэнэ:

3.1.1. Монгол Улсын хилийг бүлэг жуулчид нэрсийн жагсаалтаар нэвтрэх бөгөөд жагсаалтад аялал зохион байгуулж байгаа тур операторт бүртгүүлсэн жуулчин бүрийн эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, албан ёсоор оршин суух хаяг, “орох, гарах зорчих үнэмлэхийн дугаар”, автотээврийн хэрэгслийн дугаар болон холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг бусад мэдээллийг тусгасан байна;

3.1.2. бүлэг жуулчны хөтөч-тайлбарлагч нь Улсын хил хамгаалах байгууллага болон Аялал жуулчлалын тухай хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс олгосон “Хил орчмын аялал жуулчлалын Жуулчны хөтөч-тайлбарлагч”-ийн үнэмлэхээр хил нэвтрэнэ;

3.1.3.энэ журмын 3.1.2-т заасан бүлэг жуулчны хөтөч-тайлбарлагч нь гадаад улсын иргэн байх тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас Монгол Улсад нэвтрэх үнэмлэхийг авсан байна;

3.1.4.бүлэг жуулчдыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон зорчигч тээвэрлэх, жолоодох эрхийн үнэмлэхтэй байна.

3.2.Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах тур оператор хилээр нэвтрэхдээ энэ журмын 3.1-д заасан бүлэг жуулчны нэрсийн жагсаалт, жуулчны хөтөч-тайлбарлагч, жолоочийн мэдээллийг бүрдүүлж Улсын хил хамгаалах байгууллагад өгнө.

3.3.Улсын хил хамгаалах байгууллага шаардлагатай тохиолдолд тур оператораас нэмэлт баримт, мэдээллийг гаргуулан авч болно.

3.4.Жуулчны хөтөч-тайлбарлагч, бүлэг жуулчид хил нэвтрэх баримт бичгээ гээж үрэгдүүлсэн тохиолдолд энэ талаар харьяалах улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэж, үнэмлэхээ үрэгдүүлснийг нотолсон бичигтэйгээр хил нэвтрэнэ.

3.5.Хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт аялах бүлэг жуулчид биеийн давхцахгүй өгөгдлийг шалгуулан улсын хилээр нэвтрэнэ.

Дөрөв.Тур операторын хүлээх үүрэг

4.1.Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тур оператор нь Улсын хил хамгаалах байгууллагатай “Улсын хилийн зурвас, бүсэд мөрдөх журам сахиулах гэрээ” байгуулж ажиллах бөгөөд дараах материалыг бүрдүүлж, Улсын хил хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авна:

4.1.1.тухайн тур оператор Аялал жуулчлалын тухай хуулийн 12.1.2, 12.1.3-т заасан ангиллаар бүртгүүлсэн талаарх мэдээлэл;

4.1.2.аяллын маршрут, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл;

4.1.3.Монгол Улсын хилийн тухай хуулийн 25.4-т заасан баримт бичиг.

4.2.“Улсын хилийн зурвас, бүсэд мөрдөх журам сахиулах гэрээ” нь Монгол Улсын хилийн тухай хуулийн 26.1, 30.1-д заасан улсын хилийн зурвас, улсын хилийн бүсэд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:



4.2.1. тухайн тур операторын хил орчмын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах маршрутын мэдээлэл;

4.2.2. хилийн аюулгүй байдлыг хангах талаар талуудын эрх, үүрэг;

4.2.3. хил орчмын аялал жуулчлалын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулахад баримтлах дэглэм;

4.2.4. энэ журмын 4.2.3-т заасан дэглэмийг зөрчсөн үйлдлийн талаар улсын хил хамгаалах байгууллагад мэдээлэх асуудал.

4.3. Тур оператор нь хилийн зурвасын бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах тохиолдолд Улсын хил хамгаалах байгууллагаас хилийн зурвасын аюулгүй байдлыг хангах, хориглосон үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор албан хаагчийг томилж болно.

4.4. Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллага Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүхий газар, түүний хэвлийд хүндэтгэлтэй хандан, хамгаална.

4.5. Хил орчмын аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах тур оператор нь үйл ажиллагаагаа явуулахдаа “Улсын хилийн зурвас, бүсэд мөрдөх журам сахиулах гэрээ”, хууль болон холбогдох дүрэм, журам, Улсын хил хамгаалах байгууллагын ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Тав. Хил дамнансан аялал жуулчлал

5.1. Олон улсын аялал жуулчлалын арга хэмжээ (цаашид “арга хэмжээ” гэх)-нд оролцогчид Монгол Улсын хилээр нэвтэрч, нутаг дэвсгэрээр дайран өнгөрч болно.

5.2. Арга хэмжээнд оролцогчид Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөхдөө зөвхөн Улсын хил хамгаалах байгууллагын заасан боомтоор хил нэвтэрч, батлагдсан маршрутын дагуу зорчино.

5.3. Арга хэмжээ зохион байгуулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хүсэлтийг доор дурдсан мэдээллийн хамт аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад арга хэмжээ зохион байгуулахаас 15-30 хоногийн өмнө хүргүүлнэ:

5.3.1. арга хэмжээний зорилго, оролцогч улсууд, явагдах үйл ажиллагааны төрөл, онцлог, аюулгүй байдлыг хангах мэдээлэл, түр буудаллах хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан танилцуулга;

5.3.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх оролцогчдын нэрсийн жагсаалт;

5.3.3. Монгол Улсын хилээр нэвтрэх автотээврийн хэрэгслийн жагсаалт;

5.3.4. бусад.

5.4. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 5.3-т заасан мэдээллийг Улсын хил хамгаалах байгууллага болон оролцогч бусад байгууллагын саналыг авч хамтран ажиллана.

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Энэ журмын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил, улирал тутам хийж гүйцэтгэнэ.

6.2. Аялал жуулчлалын тухай хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааны тайланг дараа сарын 05-ны дотор аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

6.3. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улирлын тайланг дараа улирлын эхний сарын 05-ны дотор нэгтгэж, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороонд танилцуулж, мэдээллийг Аялал жуулчлалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан мэдээллийн санд байршуулна.

Долоо. Бусад

7.1. Монгол Улсын хил хамгаалах байгууллагаас хил орчмын аялал жуулчлал зохион байгуулагдаж байгаа нутаг дэвсгэрт хил зөрчигчийг саатуулах, улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн үйлдлийг таслан зогсоох зорилгоор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд тур оператор дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.



7.2. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг хилээр нэвтрүүлэхийг завдсан гадаадын иргэнийг аялал жуулчлалын зорилгоор хил нэвтрүүлэхгүй.

7.3. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын хил хамгаалах байгууллага, хилийн хяналтын болон холбогдох бусад байгууллагууд энэ журмыг хэрэгжүүлэх асуудлаар тухай бүр мэдээлэл солилцох, хуралдах, шаардлагатай тохиолдолд хамтарсан Ажлын хэсэг байгуулах замаар хамтран ажиллана.

7.4. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.5. Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----

хэсэгт 10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн

10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн

10.06-д үзүүлсэн

10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн

10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн

10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн

10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн

10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн

10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн
10.06-д үзүүлсэн



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Соёлын тухай хуулийн 32.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хүүхдэд зориулсан уран бүтээлд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Хүүхдэд зориулсан уран бүтээлд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг жилд 300,000,000 (гурван зуун сая) төгрөг байхаар тооцож, жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2007 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 280 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН



Засгийн газрын 2024 оны 04 дүгээр
сарын 17-ны өдрийн 161 дүгээр
тогтоолын хавсралт

ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН УРАН БҮТЭЭЛД ТӨРӨӨС САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад соёл урлагийн байгууллага, уран бүтээлчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, бүтээлийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Хүүхдэд зориулсан уран бүтээл (цаашид “бүтээл” гэх)-д төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд Соёлын тухай хууль, Иргэний хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр.Бүтээлийн төрөл, тавигдах шаардлага

2.1.Хүүхдэд зориулсан уран бүтээлийн дараах төрөлд санхүүгийн дэмжлэг олгоно:

2.1.1.дуурь: сонгодог болон үндэсний;

2.1.2. жүжиг: бүжгэн, дуулалт, драм, хүүхэлдэйн;

2.1.3.концертын бүтээл: хүүхдэд зориулсан дуу, найрал дуу, хөгжмийн бүтээл;

2.1.4.циркийн хөтөлбөр;

2.1.5.ном: уран зохиол, танин мэдэхүйн, сэтгүүл;

2.1.6.нэвтрүүлэг: өв соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн, цуврал контент;

2.1.7.цахим бүтээл: өв соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн, сургалтын агуулга бүхий аппликейшн.

2.2.Бүтээл дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1.оюуны өмчийн болон зохиогчийн эрхийн зөрчилгүй байх;



2.2.2. зохиогчийн эрхийг лиценз, франчайз, мерчандайзийн болон бусад гэрээ, хэлцлээр ашиглуулах, өмчлөх эрх шилжүүлэх, оюуны өмчөөр хуулийн этгээдэд хөрөнгө оруулах, барьцаалах болон бусад хэлбэрээр байгууллага, хувь хүнтэй гэрээ байгуулаагүй байх;

2.2.3. хүүхдийн нас, сэтгэхгүйн онцлогт тохирсон, тэдний сонирхол, сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн, шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан хүүхдэд ойлгомжтой байдлаар харуулсан байх;

2.2.4. Монгол хэлний хэл зүй, найруулга зүйн шаардлагыг хангасан, үгийн зөв сонголттой, этгээд, бүдүүлэг үг хэрэглээгүй байх;

2.2.5. өргөн нэвтрүүлэг, дэлгэцийн бүтээлд насны ангиллын таних тэмдэглэгээг оруулж ном, танилцуулга хэвлэсэн байх;

2.2.6. садар самуун, хүчирхийлэл, согтууруулах болон мансууруулах бодис, хүн алах, хүүхдийн эсрэг гэмт хэргийг сурталчлаагүй байх.

Гурав. Бүтээлийг бүртгэх, сонгон шалгаруулах

3.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүтээлийг сонгох, үнэлэх болон бүртгэх, мэдээлэх, тухайн мэргэжлийн урлагийн байгууллага бүтээлийг сурталчлах, нийтийн хүртээл болгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгэх бөгөөд тухайн жилд дэмжлэг үзүүлэх уран бүтээлийн төрөл, сэдвийг тодорхойлон сонгон шалгаруулах зарыг тухайн жилийн 9 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан төрийн захиргааны байгууллагын албан ёсны цахим хуудас болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

3.2. Сонгон шалгаруулалтад оролцох байгууллага, уран бүтээлч бүтээж туурвисан уран бүтээлийг дараах баримт бичгийн хамт энэ журмын 3.1-д заасан хугацаанд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:

3.2.1. албан бичиг, хүсэлт өргөдөл;

3.2.2. бүтээлийн танилцуулга (зураг, видео бичлэг гэх мэт дэлгэрэнгүй);

3.2.3. санхүүгийн төсөл;

3.2.4. төслийн багийн танилцуулга, ажлын туршлага;

3.2.5. гүйцэтгэх ажлын хуваарь.

3.3. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр тухай бүр орон тооны бус сонгон шалгаруулах Ажлын хэсгийг байгуулж, ажлын удирдамжийг батална.

3.4. Сонгон шалгаруулалтыг тухайн жилийн 11 дүгээр сард багтаан доор дурдсан 2 үе шаттайгаар зохион байгуулна:

3.4.1. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтаар энэ журмын 3.2-т заасан баримт бичгийн бүрдэл болон дуу, дүрсний бичлэгийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн сонгон шалгаруулах;

3.4.2. Хоёрдугаар шатны шалгаруулалтаар энэ журмын 2.2-т заасан бүтээлд тавигдах шаардлагыг хангасан бүтээлүүдийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд танилцуулж, сонгон шалгаруулах Ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн 3.1-д заасан бүтээл тус бүрээс сонгон шалгаруулна.

Дөрөв. Сонгон шалгаруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, эрх, үүрэг

4.1. Сонгон шалгаруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан, кино, драм, хөгжим, утга зохиол, ном хэвлэл, урлаг судлалын чиглэлээр болон хүүхэд, гэр бүл хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдсэн нийт есөн гишүүнтэй байна.

4.2. Сонгон шалгаруулах Ажлын хэсэг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. тухайн бүтээлийн төсөл нь энэ журмын 2.2-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоож, үндэслэл бүхий дүгнэлт гаргах;

4.2.2. бүтээлийн цар хүрээ, ач холбогдлыг харгалзан санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох.

4.3. Сонгон шалгаруулах Ажлын хэсгийн хуралд гишүүдийн олонх оролцоноор хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авсан бүтээлд дэмжлэг үзүүлэх тухай дүгнэлт гаргана.

4.4. Сонгон шалгаруулах Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлын товыг зарлах, хэлэлцэх асуудлыг боловсруулж гишүүдэд



танилцуулах, холбогдох баримт бичгийн бүрэн гүйцэд байдлыг хангах, хурлын тэмдэглэлийг үнэн, зөв хөтлөх үүрэгтэй бөгөөд хуралд саналын эрхгүй оролцоно.

4.5.Сонгон шалгаруулах Ажлын хэсгийн гишүүн тухайн жилийн сонгон шалгаруулалтад бүтээлээ оролцуулж байгаа бол Ажлын хэсгийн гишүүнээр оролцохоос татгалзах үүрэгтэй.

4.6.Сонгон шалгаруулах Ажлын хэсгийн гишүүн нь албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаа, ашиг сонирхол, хамаарал бүхий этгээдийн нөлөөнд автахгүй, хараат бус байх зарчмыг баримтлан ажиллана.

Тав.Бүтээлд дэмжлэг үзүүлэх хөрөнгийн зарцуулалт

5.1.Сонгон шалгаруулалтын Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бүтээлд дэмжлэг үзүүлэх тухай шийдвэр гаргана.

5.2.Хүүхдэд зориулсан бүтээлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөрөнгийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ. Уран бүтээл бүрд олгох санхүүгийн дэмжлэг нь тухайн бүтээлийн санхүүгийн дэмжлэг хүссэн саналын 70 хүртэлх хувь байна.

5.3.Шалгарсан этгээд бүтээлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй.

Зургаа.Бүтээлийн зохиогчийн эрх ба ашиглалт

6.1.Зохиогч зөвшөөрсөн тохиолдолд тухайн байгууллага Зохиогчийн эрхийн тухай хуульд заасны дагуу зохиогчтой бүтээл ашиглах гэрээг байгуулна.

6.2.Бүтээлийг энэ журмын 6.1-д заасан гэрээнд дараах хэлбэрээр ашиглахаар тусгана:

6.2.1.соёл урлагийн байгууллага бүтээлийг урын санд багтаан ашиглах;

6.2.2.бүтээлүүдийг сурах бичиг, сургалтын хөтөлбөрт тусгах;

6.2.3.түүхэн тэмдэглэлт ойн баяр наадам болон бусад хүндэтгэлийн тоглолт, арга хэмжээнд тусган нийтийн хүртээл болгох;



6.2.4.олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцуулах, Монгол Улсыг гадаад, дотоодод сурталчлах арга хэмжээний хөтөлбөрт багтаах;

6.2.5.Зохиогчийн эрхийн тухай хуульд заасан бусад эрх.

Долоо.Бусад

7.1.Энэ журмыг зөрчсөн хүн, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---



Хүснэгт 3-ийн 4-д үзүүлсэн үзүүлэлтүүдийн үндсэн дээр **«Ирээдүйн Армения»** ХХК-ийн үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго

Энгийн үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго - 4 - 5

Хүснэгт 3-ийн 6-д үзүүлсэн үзүүлэлтүүдийн үндсэн дээр

«Ирээдүйн Армения» ХХК-ийн үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго

Энгийн үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго - 4 - 5

«Ирээдүйн Армения» ХХК-ийн үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго

Энгийн үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго

Энгийн үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго

Үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго

Энгийн үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго

Үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго

Энгийн үйлдвэр, ажлаа хөгжүүлэх үндсэн зорилго



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 176

Улаанбаатар
хот

Үзэл баримтлал батлах тухай

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг үндэслэн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.3.4-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан үзэл баримтлалд үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, турших, хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, зохион байгуулж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр
сарын 24-ний өдрийн 176 дугаар
тогтоолын хавсралт

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
(2024-2036)**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Хууль, эрх зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7-д Монгол Улсын иргэний “сурч боловсрох эрх”-ийг баталгаажуулан хуульчилсан. Түүнчлэн, 2015 онд Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар хэлэлцэж баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго-2030” хөтөлбөрт “Бүх түвшинд тэгш, чанартай боловсрол олгох, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих” зорилгыг боловсролын салбарт дэвшүүлжээ.

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн нэг чухал хэмжээс нь хүний хөгжил бөгөөд улс орны засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол цөм, хөдөлгөгч хүч нь болохын хувьд Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг баталж, хүн төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд энэ бодлогын 2.1-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлсэн байна.

Мөн 2021-2030 онд хэрэгжүүлэх Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөнд “Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан, мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх, дижитал технологийн эринд ажиллаж амьдрах, нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай, эрүүл иргэнийг цогцоор хөгжүүлэх”-ээр заажээ.

Дээрх зорилго, зорилтын хүрээнд боловсролын хөгжлийн олон улсын чиг хандлага, өөрийн улсын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан боловсролын зорилгыг шинэчлэх, хувьсан өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнцөд шинээр бий болж буй өргөн боломж, түүний



дотор технологийн дэвшлийг ашиглан мэдлэг, боловсрол эзэмших арга хэлбэрийг уян хатан, тэгш, хүртээмжтэй хөгжүүлэхийн зэрэгцээ бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монгол хэл, түүх соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлэх замаар сургалтын чанар, үр нөлөөг сайжруулах бодит хэрэгцээ, шаардлага нэмэгдсээр байна.

Иймд Боловсролын ерөнхий хуулийн 14.3-т “Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын хөтөлбөр, агуулгатай холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна” гэж, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.1-д “Сургалтын хөтөлбөр үзэл баримтлалтай байх бөгөөд уг үзэл баримтлалыг Боловсролын ерөнхий хуулийн 23.3-т заасан Боловсролын үндэсний зөвлөл хэлэлцэж, Засгийн газар батална” гэж тус тус заасныг баримтлан Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т “Бүх шатны боловсролын тогтолцоо, агуулгын нэгдмэл бодлого боловсруулж хэрэгжүүлэх.” гэж заасан Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд үндэсний сургалтын хөтөлбөрүүдийн залгамж холбоотой, тогтвортой байх нөхцөлийг хангах зорилгоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-ыг батлан мөрдүүлэх хууль зүйн шаардлага үүсэж байна.

1.2. Практик шаардлага

Үндэсний болон олон улсын боловсролын үзэл баримтлал, сургалтын хөтөлбөр, стандартын өөрчлөлт, шилжилтийг судалж үзэхэд хөгжлийнхөө явцад шинэчлэгдэн тэсч үлдэх (1959-1978), техник, технологийн хөгжилд чиглэх (1976-1996), чадамжид суурилах (1997-2024), улмаар үндэсний хөгжлийг зорилтуудтай уялдуулах зэрэг нийтлэг чиг хандлага ажиглагдаж байна.

Монгол Улсын хувьд нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжсэнээс хойш сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын цөөнгүй хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэн боловч тэдгээрийг нэгдсэн үзэл баримтлалын хүрээнд боловсруулж, хэрэгжилтийг тогтвортой хангах санхүү, төсөв болон багшийн хөгжлийн урьдач нөхцөлийг хангалттай бэлтгэж чаддаггүй байсан нь сорилт, бэрхшээл болж ирсэн.

Энэ нь Монгол Улсын нийгмийн суурь болсон хүний хөгжилд сөрөг нөлөө үзүүлж, хүний нөөцийн бүтээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэртэй бус байдал бий болоход нөлөөлсөн гэж үзэх үндэс байгааг 2018-2023 онд хийсэн үндэсний болон олон улсын судалгааны баримтуудаас үзэж болно. Тодруулбал,

Монгол Улсын үйлдвэрлэлд нэвтэрч буй технологийн дэвшил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааны үр дүн суралцагчдад орчин үеийн ажиллах хүчинд шаардлагатай болж буй технологийн болон дижитал чадвараас гадна асуудал шийдвэрлэх, шүүн тунгаах, харилцах, багаар ажиллах, дасан зохицох зэрэг зөөлөн чадварт сургах, эдийн засаг, санхүүгийн боловсрол, ажил мэргэжлийн чиг баримжаа, аж ахуй эрхлэх ухааны суурь мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, улмаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг хангах шаардлагатайг харуулж байна¹.

Технологийн дэвшил, хүний хөгжлийн онцлог, хэрэгцээтэй уялдуулан хүн болохуй, суралцахуйн олон янзын, олон талт арга замыг тусгасан хөтөлбөрийг хөгжүүлж, хэрэгжүүлэх шаардлага нэгэнт бий болсон байна.

2023 оны судалгаагаар 6 настай суралцагчийн сургуульд бэлтгэгдсэн байдал 72.3 хувь², ерөнхий боловсролын 2 дугаар ангийн суралцагчийн унших чадвар 41.4 хувь, математикийн чадвар 49 хувь³, дунд ангийн суралцагчийн монгол хэлний түвшин 50.5 хувь, математик 34.8 хувь, англи хэл 26.3 хувь, физик 26.1 хувьтай⁴ байгаа нь үндэсний сургалтын чанарыг дээшлүүлэх онцгой шаардлагатайг илтгэж байна.

Цаашид хүүхэд, залуучуудын суурь чадамж, тэр дундаа тоо тоолол, бичиг үсэг, мэдээлэл харилцаа, технологийн чадамжийг хөгжүүлэх, цар тахал болон бусад хүчин зүйлээс үүдэлтэй сурлагын хоцрогдлыг нөхөх зайлшгүй шаардлага үүссэний зэрэгцээ дижитал төрмөл хэмээгдсэн шинэ үеийнхний өвөрмөц онцлог, мэдээллийн технологийн ололтод тулгуурлан хувь хүний ялгаатай хэрэгцээ, суралцахуйн хэв маягт тохирсон уян хатан, олон хувилбарт сургалтын хөтөлбөрийн шинэчлэл чухал болж байна.

Монгол Улсад хэрэгжиж буй сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт туссан чадамжийг олон улсын түвшинд хэрэгжүүлж байгаа ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн нийтлэг чадамжийн үзүүлэлтүүдтэй харьцуулж үзэхэд⁵, эрсдэл хүлээх, зөрчилдөөнийг шийдвэрлэх, дасан зохицох, бусдын оронд өөрийгөө тавьж үзэх, нийгэм ба улс төрийн үзэл санаанд суурилж иргэний амьдралд

¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт. (2023). Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал боловсруулах зөвлөх үйлчилгээний тайлан /зөвлөмж хэсэг/

² Боловсролын үнэлгээний төв (2022). Нэгдүгээр ангийн суралцагчдын сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний эцсийн тайлан.

³ Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын чанарын шинэчлэл төсөл. (2023). Бага ангийн сурагчдын унших, математикийн чадварын үнэлгээний үр дүн.

⁴ Боловсролын үнэлгээний төв. (2019). Суурь боловсролын чанарын үнэлгээний судалгааны тайлан.

⁵ Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн. (2022). Сургалтын хөтөлбөрт туссан чадамжийн шинжилгээний тайлан.



оролцох, ардчилсан оролцоонд үүрэг хүлээх, хувийн болон нийгмийн хариуцлага, тууштай байдал зэрэг чадварыг цаашид сургалтын хөтөлбөрт нэмж тусгах нь зүйтэй гэсэн үр дүн гарчээ.

Сурах бичигт хийсэн шинжилгээгээр⁶ нийгэм, эдийн засгийн хөгжил, онцлог, дархан цаазат ба дурсгалт газар, байгалийн нөөц баялаг, хүмүүн хийгээд байгалийн харилцааны үнэт зүйл, эдийн засаг болон улс төрийн үнэт зүйл эзэмшүүлэхэд чиглэсэн агуулга хангалтгүй, танин мэдэхүйн дээд эрэмбийн сэтгэх чадварыг дэмжсэн дасгал даалгавар багатай байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн болон Боловсролын үнэлгээний төвөөс 2018-2022 онд хийсэн сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа, оношлох үнэлгээ, сурах бичгийн шинжилгээний үр дүнгээр сургалтын хөтөлбөр, сурах бичигт туссан агуулга нь танин мэдэхүйн сэргээн санах ойлголтын түвшинд төвлөрсөн, хэрэглээний болон бүтээлч түвшинд анхаарал хандуулаагүй гэсэн ижил дүгнэлтэд хүрсэн байна.

Суралцагчийн үнэлгээний олон улсын хөтөлбөр (ПИСА-2022) -ийн⁷ үр дүн (математик - 425, байгалийн ухаан - 412, унших чадвар - 378 оноотой үнэлэгдсэн) ч манай улс ерөнхий боловсролын сургалтын чанараа ахиулах зайлшгүй шаардлагатайг илтгэж байна.

Энэ бүхнийг дүгнэвэл, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл давтамжтай хийгдэж ирсэн ч үзэл санааны хувьд “судлагдахууны агуулга төвтэй сургалтын хөтөлбөр” бүрэн өөрчлөгдөхгүй байгааг харуулж байна.

Суралцагчдын академик гүйцэтгэлээс гадна тэдний өв тэгш хөгжил, төлөвшилд анхаарал хандуулж, суралцагч бүр өөрийн гэсэн суралцах арга барилтай, сургуульд элсэх үед өмнөх мэдлэг, чадвар, хандлага нь харилцан адилгүй байдгийг хүлээн зөвшөөрсөн сургалтын арга зүйг тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2023 онд шинэчлэн баталсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд “Сургалтын хөтөлбөр нь үзэл баримтлалтай байна” гэж зааж, түүнийг Боловсролын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, Засгийн газар батлахаар хуульчилсан нь сургалтын хөтөлбөрийн чанар, тогтвортой байдлыг хангах эрх зүйн нэн чухал зохицуулалт болсон билээ.

⁶ Боловсрол, шинжлэх ухааны яам, Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл. (2021). Ерөнхий боловсролын сурах бичигт хийсэн шинжилгээний дүнгийн тайлан.

⁷ Эдийн засаг хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага, Боловсрол, шинжлэх ухааны яам. (2022). “ПИСА-2022” Үндэсний тайлан-Монгол Улс.



Хэдийгээр боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрийн талаарх онол, олон улсын туршлага нилээд байвч Монгол Улсын засаглалын хэлбэр, эдийн засгийн бүтэц, газар нутаг, нүүдэлчин амьдрал, монгол хүний сэтгэлгээний хэв шинж зэрэг үндэсний онцлог тулгуурласан сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын арга зүй, технологи, тэдгээрийн удирдлага, зохицуулалтыг сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалдаа тодорхой тусгах, нарийвчлан томъёолох нь чухал ач холбогдолтой төдийгүй цаашид тогтвортой хөгжих үндсэн суурь бүрдэнэ гэж үзэж байна.

Иймд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг нэгдсэн үзэл баримтлалтайгаар, олон улсын боловсролын хөгжлийн чиг хандлага, монгол хүний онцлог шинжид тулгуурлан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хувь хүний хэрэгцээтэй уялдуулан боловсруулах нь цаашид хүний хөгжлийг хангах, улмаар нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн суурь нөхцөл болно гэж үзэж байна.

ХОЁР.ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

2.1.Үзэл баримтлалын зорилго

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр (цаашид “сургалтын хөтөлбөр” гэх)-ийн үзэл баримтлалын зорилго нь суралцагчийн эзэмших чадамжийг тодорхойлж, эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, судлагдахууны хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо, арга зүй, үнэлгээний нийцтэй байдлыг харгалзан боловсруулах үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино.

2.2.Монгол суралцагчийн эзэмших чадамж

Сургалтын хөтөлбөрөөр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зорилгод нийцсэн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийн цогц чадамжийг Монгол суралцагчид эзэмшүүлэх бөгөөд чадамж нь дараах суурь болон ерөнхий чадамжаас бүрдэнэ.

Суурь чадамж	<ul style="list-style-type: none"> - Эх хэл, бичиг үсэг - Математик - Шинжлэх ухаан (байгалийн ба нийгмийн) - Компьютерын ухаан ба цахим технологи - Англи хэл болон бусад гадаад хэл - Биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал
Ерөнхий чадамж	<ul style="list-style-type: none"> - Бүтээлчээр, шүүн тунгаах сэтгэлгээ - Суралцах арга барил - Харилцаа, хамтын ажиллагаа - Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил - Тогтвортой хөгжил - Үндэсний болон дэлхийн өв соёл

Чадамж нь Боловсролын ерөнхий хуулийн 14.2-т заасан мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, түүний түвшинг тодорхойлох үзүүлэлтэд нийцсэн байх бөгөөд тэдгээрийг боловсролын түвшин, шатлал, анги бүрд залгамж холбоотой, тасралтгүй хөгжүүлнэ.

2.3.Хамрах хүрээ

Энэхүү үзэл баримтлал нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, түүний бүтэц, боловсруулахад тавих шаардлага, хэрэгжүүлэх арга зам болон хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээг хамарна.

ГУРАВ.СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ БҮТЭЦ, БОЛОВСРУУЛАХАД ТАВИХ ШААРДЛАГА

3.1.Сургалтын хөтөлбөрийг боловсруулахад баримтлах зарчим

Сургалтын хөтөлбөр нь зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээ, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг тусгасан цогц баримт бичиг байна. Сургалтын хөтөлбөр нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын түвшинтэй, тус бүрд нь хамаарах судлагдахууны хөтөлбөртэй байна. Сургалтын хөтөлбөр нь чадамжид суурилсан байна.


Сургалтын хөтөлбөр нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 8.2, 9.2-т заасан агуулгыг багтаасан дараах суралцахуйн хүрээ⁸-тэй байна:

а)Сургуулийн өмнөх боловсролд хүүхдийн хөгжлийг хангахын тулд хэл яриа, нийгэмшил, математик ба цахим технологийн энгийн төсөөлөл, байгаль, нийгмийн орчин, урлаг ба бүтээлч үйл ажиллагаа, хөдөлгөөн, эрүүл мэнд;

б)Ерөнхий боловсролын түвшинд монгол хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, гадаад хэл, урлаг, технологи, биеийн тамир, эрүүл мэнд;

⁸ Суралцахуйн хүрээ нь ижил төстэй зорилго бүхий судлагдахууны бүлэг юм. Жишээлбэл, “нийгмийн ухаан” гэсэн суралцахуйн хүрээнд газар зүй, түүх, иргэншил, эдийн засаг/худалдаа, философи, социологи зэрэг багтана (UNESCO IBE. 2011).

Зураг 1. Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн хүрээ ба судлагдахуун



Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт Боловсролын ерөнхий хуулийн 14.4-т заасан агуулгыг заавал тусгах бөгөөд тухайн агуулгын хүрээнд суралцагчийн зайлшгүй эзэмших мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг тодорхойлж, үзэл баримтлалын 2.2-т заасан чадамжийг хөгжүүлэхэд чиглэнэ.

Сургалтын хөтөлбөрийг боловсролын дараах түвшин, шатлал, ангийн онцлогийг харгалзан судлагдахуун бүрээр боловсруулна.

Хүснэгт 1. Боловсролын түвшин, шатлал, анги

Нас	Түвшин	Шатлал	Анги	Сургалтын хөтөлбөр
15-18	Бүрэн дунд боловсрол		12 дугаар анги	Ахлах ангийн сургалтын хөтөлбөр
			11 дүгээр анги	
			10 дугаар анги	
11-14	Суурь боловсрол	Дунд ангийн төгсгөл	9 дүгээр анги	Дунд ангийн сургалтын хөтөлбөр
			8 дугаар анги	
		Дунд ангийн эхлэл	7 дугаар анги	
			6 дугаар анги	
6-10	Бага боловсрол	Бага ангийн төгсгөл	5 дугаар анги	Бага ангийн сургалтын хөтөлбөр
			4 дүгээр анги	
			3 дугаар анги	
		Бага ангийн эхлэл	2 дугаар анги	
			1 дүгээр анги	
2-5	Сургуулийн өмнөх боловсрол		Бэлтгэл бүлэг	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр
			Ахлах бүлэг	
			Дунд бүлэг	
			Бага бүлэг	

Сургуулийн өмнөх боловсролоос эхлэн цахим технологийн энгийн төсөөлөл, бага боловсролоос эхлэн компьютерын ухааныг судална. Бага боловсролын төгсгөл шатлалаас англи хэл, суурь боловсролд бусад гадаад хэлийг сонголттой судална.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулийн 20.6-д заасны дагуу ахлах ангийн сургалтын хөтөлбөр сонгон судлах төрөлтэй байна. Сонгон судалсан сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг үндэслэн ахлах ангийн суралцагчдад хөдөлмөрийн зах зээлд гарах нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулахад Боловсролын ерөнхий хуулийн 5.1-д зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

-Монгол хэл, сэтгэлгээ, түүх, соёл, өв уламжлал болон дэлхийн өв соёл, үнэт зүйлд суурилах;

-Насан туршийн суралцахуйг дэмжсэн байх -Суралцагч бүрийн насан туршдаа суралцах үндэс суурийг бүрдүүлэх, тэдний авьяас чадвар, чадамжийг таньж мэдэх, хөгжүүлэх, бие даан амьдрах, амжилтад хүрэх боломжийг нээх;

-Хүмүүнлэг байх -Суралцагч бүрийн эрхэм чанарыг ойлгох, хүндэтгэх, тэдний эрхийг хангах, хамгаалах хүмүүнлэг үзэл санаанд суурилах;

-Тэгш хамруулах, ялгаатай хэрэгцээг хүндэтгэх -Хэнийг ч орхихгүй байх, суралцагчийн ялгаатай хэрэгцээнд тохируулах боломж нөхцөлийг хангасан байх;

-Багшлахуй, суралцахуйн нэгдлийг хангах -Заахаас илүү суралцахуйд, өрсөлдөхөөс илүү хамтрахад чиглэсэн, олон хэл, цахим технологи ашиглаж шинэ мэдлэг бүтээх, бодит асуудалд суурилсан утга учиртай суралцахуйг дэмжсэн, суралцахуйн баяр баясал, үнэ цэнийг суралцагчдад мэдрүүлэхүйц багшлахуй, суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

-Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаанд суурилсан байх-Өөрчлөлтөд дасан зохицох, сорилт бэрхшээлийг даван туулах, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлийг төлөвшүүлэх;



-Хамтын ажиллагаанд суурилсан байх -Суралцагч болон багшийг аюулгүй, таатай орчинд сурч хөгжих, ажиллах нөхцөлөөр хангах, сургалтын дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж, хэрэгсэл ашиглах боломжийг бүрдүүлэх, сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулахад төр, хувийн хэвшил, олон нийтийн оролцоог хангах.

3.2.Сургалтын болон судлагдахууны хөтөлбөрийн нийтлэг бүтэц, боловсруулахад тавих шаардлага

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын түвшний сургалтын хөтөлбөр нь дараах нийтлэг бүтэцтэй байна:

-Түвшний ерөнхий зорилго;

-Тухайн түвшний суралцахуйн үр дүн;

-Суралцахуйн хүрээ тус бүрд суралцагчийн эзэмших чадамжийн түвшинчилсэн тодорхойлолт;

-Заавал тусгах болон орон нутаг, сургуулийн онцлогтой судлах агуулгын хүрээ;

-Суралцахуйн үндсэн онол, арга зүй;

-Суралцагчийн үнэлгээнд баримтлах ерөнхий чиглэл;

-Сургалтаас гадуурх үйл ажиллагааны ерөнхий хүрээ.

Судлагдахууны хөтөлбөр нь дараах нийтлэг бүтэцтэй байна:

-Судлагдахууны хөтөлбөрийн зорилго;

-Анги бүрийн суралцахуйн үр дүн - суралцахуйн зорилт;

-Анги бүрээр гаргасан тухайн судлагдахуунаар эзэмших чадамжийн тодорхойлолт;

-Агуулга (агуулгын залгамж холбоо бүхий ай, сэдэв);

-Суралцахуйн онол, сургалтын арга, хэлбэр;

-Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн;

-Үнэлгээний шалгуур, үнэлэх аргачлал, жин.

Ахлах ангийн сонгон судлах сургалтын хөтөлбөр нь кредит дүйцүүлэх, хөрвүүлэх болон мэргэжлийн эрх олгох сургалт зохион байгуулах удирдамжийг багтаасан байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

-Сургалтын хөтөлбөрийг суралцахуйн загварын онол, бодит суралцахуйн онол болон конструктивист онолд суурилж боловсруулсан байх;

-Сургалтын болон судлагдахууны хөтөлбөр нь уялдаа холбоотой байх;

-Судлагдахууны хөтөлбөрийн зорилго, зорилтыг тухайн түвшний сургалтын хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, биелэх боломжтой, суралцахуйн үр дүнг илэрхийлсэн байдлаар тодорхойлсон байх;

-Судлагдахууны агуулгыг шинжлэх ухааны үндэслэлтэй сонгосон, агуулгын ерөнхий болон дэд ай, хамаарах сэдвийг суралцагчийн эзэмших шаардлагатай мэдлэг, чадвар, хандлага, төлөвшилтэй уялдуулан тодорхойлсон байх;

-Практик үйлд баримжаалсан, суралцагчийн амьдрал, хөгжилд ач холбогдолтой сургалтын идэвхтэй арга зүйг санал болгосон, жишээгээр тайлбарласан байх;

-Үнэлгээний шалгуур нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилт, суралцахуйн үр дүнг хэмжихүйц, үнэлгээний даалгавар боловсруулахад чиглэл болохуйц байх;

-Суралцагчийн хөгжлийг дэмжсэн сургалтаас гадуурх үйл ажиллагааг жишээ, удирдамжтайгаар санал болгосон байх;

-Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин, хэрэглэгдэхүүний жагсаалтыг гаргасан байх.

3.3.Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд тэгш хамруулах зарчим, арга зүйг баримтлах

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшихэд суралцагч бүрд адил тэгш боломж бүрдүүлэх зорилгоор тэдний ялгаатай хэрэгцээг харгалзан, сургалтын хөтөлбөрт талуудын оролцоотой тохируулга хийж, хэрэгжүүлнэ. Үүнд:

-Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө: Ялгаатай хэрэгцээтэй суралцагч бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэгийг үзүүлэх хэрэглэгдэхүүн бөгөөд тухайн суралцагчид хүртээмжтэй, чанартай боловсрол олгох нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

-Дэмжих сургалтын хөтөлбөр: Суралцагчийн сургууль завсардалт болон сурлагын хоцрогдлыг нөхөх, тэдний хөгжлийг дэмжихэд зориулсан байна.

-Нэмэлт сургалтын хөтөлбөр: Ерөнхий боловсролын түвшинд оюуны өндөр чадамжтай, авьяастай суралцагчид зориулсан ахисан түвшний агуулгатай байна.

-Жишиг сургалтын хөтөлбөр: Гадаад дахь монгол хүүхдэд зориулж эх хэл, түүх, соёлын боловсрол олгоход зориулсан байна.

-Хос хэлний сургалт: Өөр хэл бүхий үндэстний цөөнхийн болон олон соёлт гэр бүлтэй суралцагчийн сургалтыг агуулга болон хэлийг интеграцчилан заах арга зүй (АХИС)-г баримталж зохион байгуулна.

ДӨРӨВ.СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АРГА ЗАМ

4.1.Сургалтын төлөвлөгөө, хугацаа

Сургалтын хөтөлбөрийг Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.4-т заасан ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, мөн хуулийн 21.3-т заасан сургалт зохион байгуулах журмыг баримтлан, мөн хуулийн 5.1, 5.2, 5.3-т заасан хугацаанд хэрэгжүүлнэ.

Хичээл болон сургалтаас гадуурх үйл ажиллагаанд зарцуулж буй нийт хугацааг сургалтын цаг гэж үзнэ.

Сургуулийн өмнөх боловсролд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа бага бүлэгт 15, дунд бүлэгт 20, ахлах бүлэгт 25, бэлтгэл бүлэгт 30 минутаас ихгүй байна.

Ерөнхий боловсролд судлагдахууны хөтөлбөрийг нэгж болон ээлжит хичээлээр төлөвлөн хэрэгжүүлнэ.

Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 1 дүгээр ангид 35 минут, бусад ангид 40-50 минут байна. Өдөрт бага ангид 6 хүртэл, дунд ангид 7 хүртэл, ахлах ангид 7 болон түүнээс дээш цаг хичээллэж болно.

4.2.Суралцахуйн онол, арга, хэлбэр



Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагчийн хөгжлийн онцлогт нийцүүлэн суралцахуйн загварын, бодит суралцахуйн, конструктивист болон хувилбарт сургалтын онолын үндсэн дээр боловсруулсан сургалтын идэвхтэй аргыг хэрэглэнэ.

Боловсролын түвшнээс хамааран дараах голлох арга зүйг хэрэглэнэ:

-Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалтад тоглоомд суурилсан, зохиолд суурилсан арга зүй;

-Бага ангийн сургалтад тоглоомын, орчинд суурилсан, шинжлэн судлах арга зүй;

-Дунд ангийн сургалтад асуудалд суурилсан болон шинжлэн судлах арга зүй, орчинд суурилсан болон хамтран суралцах арга зүй;

-Ахлах ангийн сургалтад асуудал болон төсөлд суурилсан арга зүй, шинжлэн судлах болон оролцоонд суурилсан арга зүй.

Идэвхтэй сургалтын арга зүйг танхимын болон танхимын бус, холимог сургалтад цахим технологитой хослуулан хэрэглэнэ.

4.3.Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд цахим технологийг ашиглахад баримтлах чиглэл

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд суралцагчийн унших, үзэх, сонсох идэвхтэй үйлийг дэмжсэн, бие даан ажиллах боломжтой цахим хэрэглэгдэхүүн, сургалтын нээлттэй материал, интерактив контент, платформыг ашиглана.

Цахим технологид суурилсан сургалт, төсөлт ажлуудаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь суралцахуйн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлнэ.

Сургалтын явц, үр дүнг үнэлэх, суралцахуйн анализ хийх арга зүй, цахим системийг хөгжүүлнэ.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сурах бичиг, хэрэглэгдэхүүний ашиглалт, багшлахуй ба суралцахуйн үйл явц, ахиц, үр дүнг суралцагч, багш, сургууль, аймаг, дүүрэг, улсын хэмжээнд нэгтгэх боломжтой үндэсний нэгдсэн платформтой байна.

4.4.Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, дэд бүтэц



Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, суралцагч төвтэй, сургалтын таатай орчныг бүрдүүлэхэд дараах чиглэлийг баримтална:

-Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг бүлэг дэх суралцагчийн тоог ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-ий 10 дахь хэсэгт заасан хэмжээгээр тогтооно;

-Суралцагч баяр баясгалантай, амар амгалан сурч хөгжих тэгш, хүртээмжтэй, аюулгүй орчныг төр, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоонд суурилж, бүрдүүлнэ;

-Суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн тоглоом наадгай, сургалтын материал, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ;

-Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан сургалтын орчин бүрдүүлнэ;

-Танхимын болон цахим сургалтыг зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, дэд бүтэц, сүлжээ, сургалтын системийн хүртээмжийг нэмэгдүүлнэ;

-Багшлахуй, суралцахуйн үйл ажиллагаанд эрүүл, аюулгүй, харилцааны эерэг, тааламжтай орчин бүрдүүлнэ;

-Сургалт, үйл ажиллагаанд ёс суртахууны хэм хэмжээг баримталж, суралцагчдын хувийн онцлог, ялгаатай хэрэгцээг хүлээн зөвшөөрч, тэгш, шударга хандана.

Судлагдахуун бүрээр сурах бичиг (сурагчийн ном, багшийн ном, дасгал ажлын дэвтэр)-тэй байх ба хэвлэмэл болон цахим хэлбэрээр хэрэглэнэ.

Сурах бичиг нь дараах шаардлагыг хангасан байна:

-Агуулгын хувьд уламжлал, шинэчлэлийн зохистой харьцааг баримтална;

-Боловсролын ерөнхий хуулийн 14.4-т заасан агуулгаас гадна эдийн засаг, санхүүгийн боловсрол, соёлын олон янз байдлын мэдлэг, чадвар, хандлага, төлөвшил эзэмшүүлэхэд чиглэсэн агуулга, арга зүйн шийдэлтэй байна;



-Дасгал, даалгавар нь танин мэдэхүйн дээд эрэмбийн сэтгэх чадварыг хөгжүүлэх, үнэлэхэд чиглэсэн, олон улсын үнэлгээний даалгаврын тавил, бүтцийн дагуу, үе шаттай гүйцэтгэх боломжтой байна;

-Цахим сурах бичиг дэх тайлбар, дасгал, даалгаврыг суралцагч бие даан гүнзгийрүүлэн судлах боломжийг бүрдүүлэх, гүйцэтгэлд суралцагч бүрээр өгөгдөл мэдээллийн сан үүсгэж, дүн шинжилгээ хийх боломжтой байна;

-Цахим сурах бичиг нь гар утас болон таблет ашиглан онлайн болон оффлайн горимд суралцагч бие даан судлах боломжтой байна.

4.5. Суралцагчийн үнэлгээ

Үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд суралцагчийн эзэмшсэн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт дахь мэдлэг, чадварын түвшнийг тодорхойлох, тэдэнд дэмжлэг үзүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэнэ.

Оношлох үнэлгээ нь суралцагчийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, сургалт, үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, төлөвлөхөд чиглэнэ.

Явцын үнэлгээ нь суралцагчийн ахицыг тодорхойлох, сурах үйлийг чиглүүлэх, суралцагчид тохирсон дэмжлэг үзүүлэх арга замыг тодорхойлоход чиглэнэ.

Үр дүнгийн үнэлгээ нь анги дэвших болон төгсөлтийн үнэлгээ байна. Анги дэвших үнэлгээ нь суралцахуйн үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөхөд, төгсөлтийн үнэлгээ нь суурь, бүрэн дунд боловсролоор эзэмшсэн чадамжийг хэмжихэд чиглэсэн байна.

Суралцагчийн танхимын, танхимын бус болон холимог хэлбэрээр судалсан суралцахуйн үр дүнг үнэлж, баталгаажуулна.

Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй уялдуулж, албан, албан бус боловсрол, амьдрах орчноос суралцсан мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулна.

Үнэлгээнд ашиглах даалгаврын сан нь баталгаатай, найдвартай, олон улсын жишигт нийцсэн байна.

4.6. Сургалтаас гадуурх үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч талууд

Сургалтаас гадуурх үйл ажиллагаа нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих бөгөөд дараах чиглэлийн хүрээнд хөтөлбөр, удирдамжаар хэрэгжүүлнэ:

-Суралцагчдын авьяас, сонирхлыг дэмжин хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, үйл ажиллагаа;

-Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн сургалт, үйл ажиллагаа;

-Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчдын эзэмших чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх сургуульд суурилсан үйл ажиллагаа, төсөлт ажлууд;

-Эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн Монгол Улсын түүхийн дурсгалт газруудаар аялах хөтөлбөр гэх мэт.

Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон төр, төрийн бус байгууллага, олон нийтийн түншлэлийг эрхэмлэнэ. Үүнд:

-Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоог хангахад Боловсролын ерөнхий хуулийн 40.1, 40.2-т заасан эрх, үүргийг баримтлахын зэрэгцээ тэдний сургалтын хөтөлбөрийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ;

-Сургууль, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн хамтарч ажиллах боломжийг бий болгох, үүрэг, хариуцлага, дэмжлэгийг нэмэгдүүлнэ;

-Төр, төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцад оролцох нөхцөлийг бүрдүүлэх, идэвхтэй, бүтээлч хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ;

-Оролцогч талуудад зориулсан соён гэгээрүүлэх ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон өргөн нэвтрүүлгийн суваг ашиглан бодлогын түвшинд хэрэгжүүлнэ.

ТАВ.СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

5.1.Сургалтын хөтөлбөрийн тогтвортой байдал



Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг үндэслэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.8-д заасны дагуу сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцүүлэн сайжруулж болно.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг 2-3 жил тутамд, хүснэгтэд үзүүлсэн шалгуур үзүүлэлтийн дагуу зохион байгуулна. Сургалтын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.24-т заасан ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын ангилал тус бүрээр боловсруулж, тайлагнана.

Хүснэгт 2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээний үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт (эээмшилтийн хувь)	Суурь түвшин	Хүрэх түвшин			Мэдээллийн эх үүсвэр	Байгууллага
		2025	2030	2035		
Хэл яриа, Нийгэмшил, Математикийн энгийн төсөөлөл Байгаль, нийгмийн орчны мэдлэг, чадвар, хандлага, төлөвшил	72.3	80	85	90	Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ (2022)	БҮТ
Унших чадвар	41.4	50	60	70	Бага	
Математикийн чадвар	49	55	60	70	боловсролын анхан шатны үнэлгээ	
Монгол хэл	50.5	60	70	75	Суурь боловсролын гүйцэтгэлийн үнэлгээ	
Математик	34.8	55	70	80		
Байгалийн ухаан	26.1	50	65	75		
Англи хэл	26.3	50	65	80		
Унших чадвар	61.5	70	75	80	7-14 насны хүүхдийн суурь чадвар	ҮСХ
Тоо тоолол	51.5	70	75	80		
Унших чадвар	378	400	Азийн дунджид хүрнэ	ОЕСД-ийн дунджид хүрнэ	Сурагчийн үнэлгээний олон улсын хөтөлбөр-PISA	БШУЯ
Математик	425	450				
Байгалийн ухаан	412	440				

*Үзэл баримтлалын 2.2-т тодорхойлсон суралцагчийн ерөнхий чадамжийн суурь түвшнийг 2025 онд тодорхойлно гэж үзэв.

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛАЛ

Авьяас Gifted	Суралцахуй, танин мэдэхүйн үр дүнд өөрчлөгдөн хөгжих боломжтой хүнд байгалиас заяагдсан язгуур өгөгдөл, нөөц боломж
Агуулга болон хэлийг интеграцчилан суралцахуй (АХИС) Content and Language Integrated Learning (CLIL)	Судлагдахууны агуулгыг эх хэл болон зорилтот хэлтэй интеграцчилан суралцах, заах арга зүйг илэрхийлэх нэр томьёо бөгөөд судлагдахууны агуулгыг эзэмшихэд зорилтот хэл болон эх хэлийг зэрэг ашиглаж сургалт зохион байгуулах, эх хэлийг үнэлж, хоёр дахь хэлийг дэмжсэн арга хандлага
Албан боловсрол Formal education	Боловсролын сургалтын байгууллагаар дамжуулж, эрх бүхий байгууллагаас баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу суралцагчийн боловсрол эзэмших, үр дүнг боловсролын баримт бичгээр баталгаажуулдаг зохион байгуулалттай үйл ажиллагаа
Албан бус боловсрол Non-formal education	Иргэн, хуулийн этгээдээс хүний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагаа
Амьдрах орчноос суралцахуй Informal learning	Хүний ажил, амьдрал, нийгмийн орчинд бие даан боловсрол эзэмших үйл явц
Англи хэл ба бусад гадаад хэлний суурь чадамж English and other foreign languages competence	Англи хэл болон бусад гадаад хэл дээр өдөр тутмын ахуй амьдрал, нийгэм, соёл, шинжлэх ухааны хүрээнд ойлгож, харилцах, бусад үндэстний хэл, соёлыг хүндэтгэх, мэдээлэлтэй ажиллах, өөрийн сонирхол, эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн гадаад хэлний мэдлэгээ бүтээлчээр хэрэглэх мэдлэг, чадвар, төлөвшил
Асуудалд суурилсан сургалт Problem-based learning	Суралцагчийн амьдрах, суралцах үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой цогц асуудлаар хэлэлцэж, ярилцах үйл явц. Энэ нь суралцагч асуултынхаа хариултыг олох гайхширал, эргэлзээгээ арилгах замаар мэдлэг, ойлголтоо дээшлүүлэх, баяжуулах боломжийг олгоно.



<p>Асуудал шийдвэрлэх үйл явц Problem solving</p>	<p>Асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн сэтгэхүйн цогц үйл явц. Байнга давтагддаг асуудлыг шийдвэрлэх нь урьд өмнө эзэмшсэн ижил төстэй туршлагадаа суурилан тухайн нөхцөл байдлаас зорилтот түвшинд шилждэг. Шинээр бий болсон асуудлыг шийдвэрлэх гэдэг нь тухайн нөхцөл байдлаас зорилтот түвшинд хүрэхийн тулд шинэ шийдлийг олж нээхийг хэлнэ.</p>
<p>Багшлахуй Teaching</p>	<p>Суралцагчийн суралцах үйл ажиллагааг дидактик шийдлээр дэмжих багшийн гүйцэтгэх үндсэн үйл ажиллагаа</p>
<p>Биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал Physical and emotional health, wellbeing</p>	<p>Суралцагчийн бие бялдар, сэтгэл зүй, нийгмийн сайн сайхан байдлаа хадгалах, дэмжих, сайжруулахтай холбоотой мэдлэг, чадвар, хандлага, арга барил, зан үйлийн төлөвшлийн үр дүн</p>
<p>Бодит суралцахуй Authentic learning</p>	<p>Бодит ахуй, амьдралд хэрэгцээтэй мэдлэг, ур чадвар олгох сургалт. Бодит сургалтаар багаар ажиллах, асуудал шийдвэрлэх, төсөлт ажил гүйцэтгэх, зохион байгуулах зэрэг чадваруудыг түлхүү эзэмшүүлдэг.</p>
<p>Боловсрол Education</p>	<p>Хүн төрөлхтний хөгжлийн талаар хуримтлагдсан мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйл, чадамжийг дараагийн үедээ дамжуулах үйл явц, түүний үр дүн. Энэ нь суралцахуйд чиглэсэн харилцаанд хамаарна.</p>
<p>Боловсролын агуулга Education content</p>	<p>Боловсролын тухайн түвшинд суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, төлөвшлийн цогц</p>
<p>Боловсролын түвшин Education level</p>	<p>Суралцагчийн танин мэдэхүйн түвшингүүдэд харгалзах боловсролын үечлэл</p>
<p>Боловсролын шатлал Education stage</p>	<p>Боловсролын зохион байгуулалтын түвшинд харгалзах үечлэл</p>
<p>Бусдын сэтгэл санааг ойлгож харилцах чадвар Empathy</p>	<p>Харилцааны үед бусдын сэтгэл санааны байдлыг ойлгох, хуваалцах харилцааны чадвар. Хүнд анхаарал халамж тавих, туслахыг эрмэлзэх, хүмүүсийн оронд өөрийгөө тавьж ойлгох, сэтгэл санаагаар дэмжих, бусдын сэтгэлийн хөдөлгөөнтэй өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг нийцүүлэх, хүмүүс юу бодож мэдэрч байгааг анзаарах зэрэг нь тухайн чадварын илрэл</p>



Бүтээлч байдал Creativity	Анхдагч бөгөөд үр дүнтэй санаа, шинэлэг шийдэл, мэдлэгийн ахиц дэвшил, төсөөлөл, илэрхийлэлд хөтлөх өвөрмөц санаа гаргах, тэдгээрийг үнэлэх, сайжруулахад үр бүтээлтэй оролцох чадвар
Гүйцэтгэлийн үзүүлэлт Performance indicators	Сургалтын байгууллага, эсхүл хэрэгжүүлж буй хөтөлбөр нь чанарын хэмжүүрт хэрхэн нийцэж байгааг илтгэх статистик хэмжигдэхүүн
Гүйцэтгэлийн шалгуур Performance criteria	Стандарт биелэлтийг үнэлэхэд хэрэглэх босго түвшин, эсхүл жишиг. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь оноо, эсхүл дүнгээр амжилтын шатлалыг илэрхийлэн, суралцагч юу мэдэх, ямар ур чадвар эзэмших ёстой тухайд хүлээсэн үр дүндээ хэрхэн хүрч байгааг харуулна.
Дадал Acquirement	Үйлдлийг зөв гүйцэтгэх оюун санааны болон биеийн хэвшил болсон ур чадвар
Дасан зохицох чадвар Adaptability	Хүрээлэн буй орчны өөрчлөлт, түүний зүгээс тавигдаж байгаа шаардлагад нийцэж зохицох чадвар
Даяарчлал Globalization	Хүмүүс, байгууллагын харилцан ажиллагаа, нэгдэл, харилцан хамаарал үндэсний хил хязгаараас хальж буй хөдөлгөөн буюу улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа, хөрөнгө, хүн ам, технологийн болон мэдээллийн өсөн нэмэгдэж байгаа урсгал
Дэлхийн иргэний боловсрол Global citizenship education	Дэлхий нийтэд тулгарсан бэрхшээлийг даван туулах, тэдгээрийг шийдвэрлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэх, илүү тайван, тэсвэр тэвчээртэй, оролцоотой, аюулгүй ертөнцийг бүрдүүлэхэд идэвх санаачилгатай оролцогч байх суралцагч бэлтгэхэд чиглэсэн боловсролын чиглэл
Ерөнхий боловсрол General education	Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүхий нийт 12 жилийн хугацаанд эзэмших боловсрол
Ерөнхий чадамж General competencies	Мэдлэгт суурилсан нийгмийг бүтээх, хувь нэмрээ оруулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг илэрхийлж буй ерөнхий ойлголт
Ёс зүй Ethics	Ёс суртахууны мөн чанар, агуулгыг судалдаг, философийн салбар шинжлэх ухаан. Ёс зүй нь нийгмийн бүлгүүд, тэдгээрийн харилцаанд ёс суртахууны хэм хэмжээ, зарчмуудыг бий болгодог.



Ёс суртахуун Moral	Нийгмийн харилцаан дахь хүмүүсийн зан үйлийн хэм хэмжээ
Жендэрийн тэгш байдал Gender equality	Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүд амьдралынхаа туршид тэгш эрх эдэлж, тэгш боломжоор хангагдаж, үйлчилгээг тэгш хүртэх явдал. Хүмүүсийн эрх, үүрэг, хариуцлага, нийгмийн байр суурь, нөөц бололцоог хүртэх боломж нь эрэгтэй, эмэгтэй гэдгээс үл хамаарч адил, тэгш байх тухай ойлголт.
Зайн сургалт Distance learning	Боловсролын агуулгыг суралцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран зохион байгуулах сургалтын үйл ажиллагаа. Зайн сургалтад МХХТ-ийн хэрэгсэл (цахим хэрэглэгдэхүүн, радио, телевиз, утас, захидал, компьютер, видео бичлэг) ашиглан зайнаас (нүүр тулан уулзахгүйгээр) сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг.
Зан үйл Behaviour	Хэн нэгний өөртөө болон бусадтай харилцах/үйл гүйцэтгэхдээ өөрийгөө авч явах арга зам
Зорилго Aim	Сургалтын байгууллагын болон сургалтын хөтөлбөрийн эрхэм зорилго, зорилт, бодлого, төлөвлөлтийн ерөнхий тодорхойлолт
Зохиолд суурилсан арга зүй Story-based learning	Үлгэр, зохиолын дүр, үг, үйл явдал, сэтгэл хөдлөлийг хүүхдэд таниулж, тэдэнд танин мэдэхүй, байгаль, нийгмийн амьдрал, сэтгэл хөдлөлийн талаар шинэ мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, учир шалтгааныг олох, төсөөллийг хөгжүүлэх интерактив арга зүй. Энэхүү арга зүй нь хүүхдийн харилцаа, зан чанар, ёс суртахууныг төлөвшүүлэх, хамтын оролцоог нэмэгдүүлэх, суралцагч төвтэй, сургалтын үйл ажиллагаагаар хэрэгждэг.
Идэвхтэй суралцахуй Active learning	Багшаас суралцагчид мэдлэгийг дамжуулах нэг чиглэлт сургалтын арга барилаас татгалзан, суралцагчийн идэвхтэй суралцах үйл явцыг дэмжих арга зүй. Идэвхтэй суралцахуй нь асуудал шийдвэрлэх, шүүн тунгаах сэтгэлгээ, харилцааны зэрэг олон талт ур чадварыг хөгжүүлдэг. Идэвхтэй суралцахуй нь хичээл, бүлгийн хэлэлцүүлэг, мэтгэлцээн, багийн ажил, хичээлээс гадуур, хамтран суралцах, кейс судалгааг ашиглах мөн танин мэдэх, нээн илрүүлэх, эрэн сурвалжлах, турших зэрэг хэлбэрүүдтэй байна.



Компьютерын ухаан ба цахим технологийн суурь чадамж
Computer science & digital technology competence

Алгоритм, компьютерын систем, программчлал, тооцоолол, их өгөгдөл, хиймэл оюун ухаан зэрэг суурь болон гүнзгий түвшний ойлголтуудыг багтаасан суралцахуйн чиглэл. Энэ нь цахим технологийн ололт амжилтыг хэрэглэх, хөгжүүлэх, компьютерын техник болон программ хангамжийг ашиглах, бүтээлч сэтгэлгээ болон асуудал шийдвэрлэх ур чадвар шаардсан даалгаврын хүрээнд системийн боловсруулалт хийх, цахим орчинд аюулгүй, ёс зүйтэй ажиллах, программ бичих чадвартай, сэтгэлгээний өндөр чадамжтай иргэнийг бэлтгэхэд чиглэнэ.

Конструктив чиг хандлага
Constructivism

Сургалтын явцад суралцагч өмнө нь эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлагадаа тулгуурлан мэдлэгийг идэвхтэйгээр өөрөө бүтээж байдаг тул багшийн өгсөн мэдлэг, мэдээллийг идэвхгүйгээр хүлээн авагч биш гэж үздэг сургалтын онол

Математикийн суурь чадамж
Mathematic basic competence

Бодит ертөнцийн олон талт нөхцөл байдалд асуудлыг шийдвэрлэхийн тулд математик үндэслэл гаргах, томъёолох, ашиглах, тайлбарлах мэдлэг, чадвар, төлөвшил

Метакогнитив мэдлэг
Metacognitive knowledge

Хувь хүний суралцах техник, танин мэдэхүйг хянахад чиглэсэн өөрийн суралцахуйг удирдах мэдлэг

Мэдлэг
Knowledge

Амьдрал, үйл ажиллагааны явцад хүмүүс ухамсарлан эзэмшиж буй хүн, байгаль, нийгмийн тухай тусгай болон ерөнхий ухагдахууны цогц. Танин мэдэхүйн үйл ажиллагааны болон тодорхой туршлагын үр дүнд бий болох ойлголт

Насан туршийн суралцахуй
Lifelong learning

Хүн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан, албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагаа

Нийгэм-сэтгэл хөдлөлийн суралцахуй
Social and emotional learning (SEL)

Өөрийгөө илэрхийлэх, нийгэм хамт олон, бусдын санаа бодлыг хүлээж авах, зүй зохистой харьцах харилцаа, сэтгэл хөдлөл, мэдрэмж, үзэл бодлоо харилцан солилцоход суралцах үйл ажиллагаа



<p>Нийгэм-сэтгэлийн хөдлөлийн чадварт суралцахуй Social and Emotional learning (SEL)</p>	<p>Харилцааны үед мэдрэмж, сэтгэлийн хөдөлгөөн, харилцаагаа удирдан зохицуулах чадварт суралцах үйл явц</p>
<p>Нийгэмшил Socialization</p>	<p>Хувь хүн нь бүлэг хүмүүстэй буюу нийгэмд зохицохын тулд нийгмийн хэм хэмжээ, үзэл баримтлал, эерэг хандлага, харилцааны чадвар эзэмших тасралтгүй үйл явц</p>
<p>Олон хэлний боловсрол Multilingual education</p>	<p>Нийгэмшлийн гол шалгуур нь нийгмийн амьдралд дасан зохицож буй чадвар, бие даан хөгжих, өөрийгөө танин мэдэх, бие даан амьдрах болон үйл ажиллагаанд оролцох чадвар юм.</p>
<p>Оношлох үнэлгээ Diagnostic assessment</p>	<p>Сургалтын байгууллагад боловсрол олгодог үйл ажиллагааг хэд хэдэн хэлээр нэгэн зэрэг зохион байгуулдаг боловсролын төрөл</p>
<p>Оношлох үнэлгээ Diagnostic assessment</p>	<p>Суралцагчийн суралцах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тэдний давуу болон сул талыг тодорхойлох үнэлгээ. Сургалтын өмнө суралцагчийн бэлэн байдал болон чадварын түвшнийг тогтооход ашиглана.</p>
<p>Орчинд суурилсан арга зүй Place-based learning, PBL</p>	<p>Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг болон сэтгэл зүй, үйлийн шаардлага хангаж буй орчинд хичээл, сургалтын үйл ажиллагааны явцад тулгамдаж буй асуудлыг тодорхой алхмуудын дагуу багш сурагчийн хамтын үйлийн хүрээнд шийдвэрлэх арга зүй</p>
<p>Өгөгдөл Data</p>	<p>Үндэслэл, хэлэлцүүлэг, эсхүл тооцооллын суурь болгон ашигладаг бодит мэдээлэл (хэмжүүр эсвэл статистик)</p>
<p>Өргөжин тэлэх сургалтын хөтөлбөр Spiral curriculum</p>	<p>Сургалтын агуулга нарийсан гүнзгийрч, өргөжин тэлэх хэдий ч сургалтын хөтөлбөрийн гол үзэл санаа байнга давтагдаж байдгаар боловсруулсан хөтөлбөр</p>
<p>Сайн сайхан байдал (сургалтын байгууллагын) Wellbeing (in institution)</p>	<p>Сургалтын байгууллагын ээлтэй, таатай байдал нь суралцагчдын бие бялдар, сэтгэл зүйн эрүүл мэнд болон хөгжилд чухал нөлөө үзүүлдэг бөгөөд сургуулийн талаарх эерэг хандлага, сургуультай холбоотой санаа зовоох асуудал, санал гомдолгүй байх, нийгэм сэтгэл зүйн ямар нэгэн асуудалгүй байх нөхцөлийг хэлнэ.</p>



Санал, зөвлөмж Feedback	Аливаа бүтээгдэхүүн, хувь хүний ажлын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор өгч буй санал, зөвлөмжийг агуулсан мэдээлэл
Соёл хоорондын харилцан ойлголцол Intercultural understanding	Өөрийн болон бусдын соёл, зан заншлыг ойлгох, таньж мэдэх, хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх хандлага
Сонгон судлах сургалтын хөтөлбөр Elective curriculum	Суралцагч сонирхол, хэрэгцээндээ нийцүүлэн сонгон судлах боломжтой хөтөлбөр
Сорил Test	Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх зорилгоор боловсруулсан шалгалтын материал, үнэлгээний дасгал ажлын нэг хэлбэр
Сорилын даалгаврын сан Test item bank	Тестийн сангийн даалгавар, эсхүл асуултын сан гэдэг нь даалгаврууд болон асуултуудын хадгалах хэрэгсэл
Судлагдахууны хөтөлбөр Syllabus	Сургалтын зорилго, зорилт, агуулгын сонголт ба дараалал, заах арга зүй, нэгж хичээл түүнд ашиглах материал, даалгавар, үйл ажиллагаа, хүлээгдэж буй үр дүн, үнэлгээний төлөвлөгөө зэргийг багтаасан баримт бичиг
Суралцагч Learner	Боловсролын сургалтын байгууллагад албан ёсоор суралцаж байгаа хүн
Суралцагчийн ялгаатай байдалд тулгуурласан заах арга зүй Differentiated instruction	Суралцагч бүрийн сурах боломжийг нэмэгдүүлэхийн тулд төрөл бүрийн сургалтын үйл ажиллагааг санал болгож, тэдний ялгаатай хэрэгцээнд нийцүүлсэн заах арга зүй
Суралцахуй Learning	Сургалтын үйл ажиллагаа, дадлага туршлага, чиглэл зааварчилгааны үр дүнд хувь хүний мэдлэг, ойлголт, үнэт зүйл, ур чадвар, чадамж, хандлага бүрэлдэн тогтох урт хугацааны цогц үйл явц
Суралцах арга барил Learning style	Хувь хүний аливааг сурах, эзэмших арга барилын онцлог, ялгаа
Суралцахуйн ахиц Learning progression	Хичээл, мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны хүрээнд мэдлэг, ур чадвар, дадал эзэмших мэдлэгийн агуулга гүнзгийрэх, нэмэгдэх, тэлэх тухай ойлголт



Суралцах боломж Opportunity to learn	Сургалтын зорилтот үр дүнд хүрэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын орчин, нөхцөлийг суралцагчдад нийцүүлэн тохируулах нөхцөл
Суралцахуйн интерактив арга Interactive teaching and learning	Суралцагчийг мэдлэг, туршлагаа хуваалцах замаар сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах арга, технологи
Суралцахуйн үр дүн Learning outcomes	Сургалтын хөтөлбөрийг амжилттай эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийн цогц. Өөрөөр хэлбэл, суралцагчийн мэдэх, ойлгох, хэрэглэх шаардлагатай хүрэх үр дүнгийн илэрхийлэл
Сургалтын агуулга Learning content	Багшлахуйн болон суралцахуйн үндэс болсон эзэмших ёстой мэдлэг, ур чадвар, үнэт зүйл болон хандлагын хүрээнд суралцах чиглэл, судлах агуулгаар бүлэглэсэн сэдэв, үзэл баримтлал, баримт мэдээ
Сургалтын нөөц ба хэрэглэгдэхүүн Learning resources	Сургалтын үйл ажиллагааг шууд ба шууд бус хэлбэрээр дэмжин сайжруулдаг аливаа биет болон биет бус нөөц. Үүнд: хэвлэмэл, хэвлэмэл бус материалууд (цахим, нээлттэй эх материал) хамаарна
Сургалтын орчин Learning environment	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн материаллаг болон сэтгэл зүйн нөхцөл, сурах, сургах харилцаа
Сургалтын төлөвлөгөө Study plan	Сургалт, судалгааны зорилгод хүрэхийн тулд судалбал зохих хичээлийн (заавал судлах хичээл, сонгон судлах хичээл, чөлөөт сонгон судлах хичээл) багц
Сургалтын хөтөлбөр Curriculum	Суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, төлөвшил, зорилго, зорилт, үнэлгээ, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүнийг тусгасан цогц баримт бичиг
Сургалтын хөтөлбөрийн зорилго Curriculum aims/goals	Сургалтын хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнг ерөнхийд нь гүйцэтгэлийн нарийн шалгуур үзүүлэлтгүйгээр өргөн хүрээнд авч үзсэн тодорхойлолт



Сургалтын хөтөлбөрийн зорилт Curriculum objectives	Сургалтын хүрэх үр дүнд заасны дагуу суралцагч юу мэддэг, чаддаг болсон байх (суралцагч юу сурч, мэдэхийг зорьсон), бүтээгдэхүүн эсвэл гүйцэтгэл (сургалтын үр дүнд суралцагч ямар бүтээгдэхүүн гаргах), үйл явцын (сургалтын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон) хэмжигдэхүйц хүлээлтүүдийг тусгасан ойрын ирээдүйд гүйцэтгэхээр шийдвэрлэсэн бодлого
Сургалтын хөтөлбөрийн интеграци Curriculum integration	Нэгдмэл, цогц сургалтыг дэмжих үүднээс сургалтын агуулгыг нэгтгэж, уялдуулах үйл явц
Сургалтын хөтөлбөрийн нийцэл Curriculum alignment	Нэгж хичээлийн заах арга зүй, үнэлгээний даалгавар, сургалтын үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрт заасан хүрэх үр дүнд нийцүүлэх, уялдуулах үйл явц
Сургалтын хөтөлбөрийн тохируулга Curriculum adaptation	Сургалтын хөтөлбөрийг чадварын хувьд ялгаатай түвшний суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн тохируулах үйл явц
Сургалтын хөтөлбөрийн удирдамж Curriculum guidelines	Багшид зориулан сургалтын хөтөлбөрийг амжилттай төлөвлөн хэрэгжүүлэх арга зам, дэг журмыг тодорхойлон боловсруулсан баримт бичиг
Сургалтын хөтөлбөрийн үнэлэлт дүгнэлт Curriculum evaluation	Албан ёсны сургалтын хөтөлбөрт тусгагдсан төлөвлөгөөт хичээл, сургалтын үйл ажиллагаа нь зорьсон үр дүнд чиглэгдэн хүрч байгаа эсэхийг хэмжих, үнэлэх үйл явц
Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт Curriculum implementation	Сургалтын хөтөлбөрийг сургалтын бодит орчин, нөхцөлд хэрэгжүүлэх үйл явц.
Сурах бичиг Textbook	Сургалтын хөтөлбөрийн зорилгод нийцсэн, шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, мэдээлэлтэй ажиллах арга барилд суралцаж, бие даан болон хамтын үйл ажиллагаагаар хэрэгцээт мэдлэгээ бүтээж, мэдлэгээ хэрэглэн аливаа тулгамдсан асуудлыг суралцахуйн онол, арга зүйн үндэс бүхий дидактик шийдлээр шийдвэрлэх сургалтын үндсэн болон сонгох хувилбар бүхий багц хэрэглэгдэхүүн



Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх цикл Curriculum review cycle	Сургалтын үйл ажиллагааг тогтмол сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх, алдаа, дутагдлыг олж илрүүлэх зорилгоор тодорхой давтамжтайгаар сургалтын хөтөлбөрийг үнэлэх, хянах, сайжруулах системтэй үйл явц
Сурлагын амжилт Learning achievement	Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц амжилт
Суурь чадамж Basic competence	Суралцах, ажиллах, амьдрахад шаардлагатай мэдлэг, түүнийг хэрэглэх, ашиглах чадамж буюу хувь хүн өнөөгийн нийгэмд амжилттай аж төрөхөд шаардлагатай хамгийн чухал чадамж
Сэтгэхүй Thinking	Юмс үзэгдлийн шинж чанар, харилцаа холбоог нэгтгэн дүгнэх, дам тусгал бүхий танин мэдэхүйн процессын дээд шат
Танин мэдэхүй Cognition	Юмсын мөн чанар, зүй тогтлын талаар мэдлэг, туршлага эзэмших үйл явц, зарчим, аргуудын нэгдмэл цогц ойлголт
Технологи Technology	Оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаа бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогц
Тоглоомд суурилсан арга зүй Play-based approach	Тоглоом, наадгайгаар дамжуулж хүүхдийн сониуч зан, бүтээлч байдал, шүүн тунгаах сэтгэлгээ зэрэг олон төрлийн мэдлэг, чадвар, төлөвшлийг эзэмшүүлдэг сургалтын арга зүй
Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) Education for sustainable development (ESD)	Дэлхийн өнөөгийн болон ирээдүйн тулгамдсан асуудлуудыг шийдэхэд сайн нөлөө үзүүлэхүйц бүтээлч байдлаар хандах, илүү тогтвортой, дасан зохицох чадамжтай нийгмийг бий болгоход чиглэсэн чадварыг суралцагчдад эзэмшүүлэх боловсролын нэг төрөл
Төлөвшил Formation	Хүмүүжил, хандлага, эрхэмлэх үнэт зүйлийн нэгдэл
Төсөлд суурилсан арга зүй Project-based approach	Тодорхой төсөл, сэдэв, үзэл баримтлалд чиглэсэн бодит асуудлуудыг судлахад суралцагчдын оролцоог дэмжих үйл явц.



Тэгш хамран сургах сургалтын хөтөлбөр (ялгаатай хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөр) Inclusive curriculum	Суралцагч бүрийн хувийн онцлог, хуримтлуулсан туршлага, хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд нийцүүлсэн сургалтын хөтөлбөр
Үзүүлэлт Indicators	Юмс үзэгдлийн илрэл, шинж чанарын тоон болон чанарын хэмжигдэхүүн
Тэгш хандах зарчим Equity	Бүх хүнд шударга, тэгш хандах
Үндэсний ба дэлхийн өв соёл National and world culture	Үндэсний болон дэлхийн түүх, соёлын өв, тэдгээрийн талаарх суралцагчийн мэдлэг, чадвар, хандлага, зан үйлийг багтаасан суралцахуйн чиглэл
Үнэлгээ Assessment	Суралцагчийн сурах үйл ажиллагааг мэдээлэх, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл явц
Үнэлгээ дүгнэлт Evaluation	Сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх, зөвлөмж өгөхөд чиглэсэн системтэй дүн шинжилгээ хийх ерөнхий үйл ажиллагаа
Үнэт зүйл Values	Субъектээс объектод хандсан харилцаа, түүнээс үүдсэн хэм хэмжээт үйлийн цогц бөгөөд хүний мэдрэмж, хэрэгцээнд тулгуурласан амьдралыг чиглүүлэн утга төгөлдөр болгох хөтлөх хүч
Үр дүнгийн үнэлгээ Summative assessment	Тодорхой хугацаанд (бүлэг сэдэв, улирал, хичээлийн жилийн төгсгөлд) суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, ойлголтыг хэмжих зорилгоор хийх үнэлгээ
Хамтран суралцахуй Collaborative learning	Гүйцэтгэлийн хувьд ялгаатай түвшний суралцагчдад нэгэн зорилгын төлөө бүлгээр хамтран ажиллаж, нийгэмших үйл явц
Хандлага Attitude	Хүн итгэл үнэмшлээрээ өөртөө, бусдад, орчиндоо хэрхэн харьцах эрмэлзэл. Хувь хүн, бүлгийн сонирхол, үнэт зүйл, үзэл бодол, итгэл үнэмшлийн илрэл

Харилцаа Communication	Хоёр ба түүнээс дээш хүн ярилцах, бичих болон бусад арга хэрэгслээр харилцан мэдээлэл солилцох, ойлголцох, нөлөөлөх үйл явц
Хичээлээс гадуурх сургалтын ажил Extra-curricular activities	Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил, оролцоо, төлөвшлийг дэмжсэн танхимын болон танхимын бус үйл ажиллагаа
Хосолсон сургалт Blended learning	Танхимын сургалтыг (ихэвчлэн интернэтэд суурилсан) зайн сургалттай хослуулсан уян хатан сургалтын хэлбэр
Хос хэлний боловсрол Bilingual education	Хоёр буюу түүнээс дээш хэлээр сургалтын үйл ажиллагаа явуулахыг дэмжсэн боловсролын нэг төрөл
Хувь хүнд тохирсон сургалт Personalized learning	Суралцагч амжилттай суралцах, зорилтот үр дүнд хүрэхэд нь туслахын тулд тэдний одоогийн нөхцөл байдал, онцлог, хэрэгцээнд боловсролыг нийцүүлэн олгох үйл явц
Хэмжигдэхүйц үр дүн Measurable outcomes	Тоон үзүүлэлтээр илэрхийлж болохуйц үр дүн, суралцагчийн хүрэх үр дүнгийн хэмжээс
Цахим сургалт E-learning	Мэдээлэл, холбоо, харилцааны технологид суурилан мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн бүх хэлбэрийн сургалтын үйл ажиллагаа
Цахим үнэлгээ буюу мэдээллийн технологид суурилсан үнэлгээ E-assessment / ICT-based assessment	Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан сургалтын үр дүнг үнэлэх үнэлгээ
Чадамж Competence	Тодорхой нөхцөл байдалд нийцэхүйц мэдлэг, чадвар, төлөвшлийн цогцоор илрэх гүйцэтгэл
Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр Competency-based curriculum	Суралцагчийн эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлсон хичээл, сургалтын дэлгэрэнгүй мэдээлэл бөгөөд сургалтын агуулга хүрэх үр дүн, заах арга зүй, орчин, үнэлгээний аргууд
Чадвар Skills	Үйлийг хэрхэн хийх талаар эзэмшсэн арга туршлагаа хэрэгжүүлэх чадавх, үйлийг амжилттай гүйцэтгэх хувь хүний дотоод арга, туршлага



Чанарын үнэлгээ Quality assessment/ quality review	Сургалтын байгууллага болон сургалтын хөтөлбөрийн чанарыг хөндлөнгөөс үнэлж буй (үнэлэх, хэмжих, дүгнэлт гаргах) дотоод үйл ажиллагаа
Шалгуур Criteria	Тодорхой зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт, эсхүл түвшин
Шинжлэн судлах арга зүй Inquiry based approach	Суралцагч судлах зүйлийнхээ талаар асуулт асуух, таамаглал дэвшүүлэх, туршилтыг төлөвлөх, сорил туршилтыг гүйцэтгэх, юмс үзэгдлийн зүй тогтол, харилцан хамаарлын учир шалтгаан, сорил туршилтын үр дүнг илэрхийлэх, тайлбарлах, үнэлэх, үр дүнгээс дүгнэлт гаргах мэдлэг, чадварыг дэмжих системтэй арга зүй
Шинжлэх ухааны суурь чадамж Science basic competence	Нийгмийн болон байгалийн аливаа юмс үзэгдлийг шинжлэх ухааны мэдлэг, ойлголт, үзэл баримтлал, хууль, зүй тогтол, онолын үүднээс шинжлэн судлах, хэрэглэх, өгөгдөл, нотлох баримтыг шинжлэх ухааны үүднээс тайлбарлахад шаардлагатай мэдлэг, чадвар, төлөвшил
Шалгуурт суурилсан үнэлгээ Criterion referenced assessment	Сургалтын үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага, төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуурт харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явц
Шүүн тунгаах сэтгэлгээ Critical thinking	Оновчтой асуулт тавих, холбогдох мэдээлэл цуглуулан бүтээлчээр ангилах, шинэ мэдээллийг мэдлэгт тулгуурлан хүлээн авах, итгэл үнэмшил, таамаглалаа эргэцүүлэн тунгаах, логик сэтгэлгээгээр учир шалтгааныг олох, бодитой дүгнэлт гаргах үйл явц
Эх хэл, бичиг үсгийн суурь чадамж Basic competence of literacy	Төрөл бүрийн эх бичвэр (бичмэл, хэвлэмэл, аман, дижитал, график дүрслэл, тоон, хөдөлгөөнт зэрэг)-ийг ойлгох, тайлбарлах, үнэлж дүгнэх, шинээр бүтээх, илэрхийлэх зэргээр нөхцөл байдалд нийцүүлэн эх хэлээ хэрэглэх мэдлэг, чадвар, төлөвшил



Явцын үнэлгээ
Formative assessment

Суралцагчийн сурлагын амжилтыг дээшлүүлэх үүднээс сургалтын явцад хийгддэг үнэлгээ бөгөөд одоогийн сурлагын амжилт болон хүрэхийг зорьсон түвшин хоорондын зөрүүг арилгахын тулд сурах үйл явцыг дүгнэх, санал зөвлөмж өгөх, тэднийг үнэлгээ болон сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах үйл явц

Ялгаатай хэрэгцээ
Different needs

Хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээ

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 181

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 46.2, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 15.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Үнэт металл, эрдэнийн чулууны жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоох, бүртгэх журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Дүрэм, журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 281 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

С.АМАРСАЙХАН



Засгийн газрын 2024 оны 05 дугаар
сарын 01-ний өдрийн 181 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ЭРДЭНИЙН ЧУЛУУНЫ ЖАГСААЛТ

Үнэт металл, эрдэнийн чулууны ангилал		Д/д	Монгол нэршил	Олон улсын нэршил, тэмдэг
1	Үнэт металл	1	Алт	Gold (Au)
		2	Мөнгө	Silver (Ag)
		3	Платина, платины бүлгийн металлууд: Палладий, Иридий, Родий, Рутений, Осмий	Platinum (Pt), Palladium (Pd), Iridium (Ir), Rhodium (Rh), Ruthenium (Ru), Osmium (Os)
2	Эрдэнийн чулуу	Үнэт чулуу		
		1	Доржпалам	Diamond
		2	Маргад	Emerald
		3	Бадмаараг	Ruby
		4	Индраанил	Sapphire
		5	Сувд	Pearl
		Хагас үнэт чулуу		
		1	Хувилгаан эрдэнэ	Alexandrite
		2	Улбар шар, ногоон, нил ягаан индраанил	Sapphire
		3	Эрдэнийн гэрэлт чимэд	Precious opal
		4	Эрдэнийн жадеит	Jadeite
		5	Демантоид	Demantoid
		6	Шпинель	Spinel
		7	Гэрэлт чимэд	Opal
		8	Усан биндэръяа	Aquamarine
		9	Молор	Topaz
		10	Родолит	Rhodolite
		11	Халтмар	Tourmaline
12	Хризолит	Peridot		
13	Циркон	Zircon		
14	Биндэръяа	Beryl		
15	Кунцит	Kunzite		
16	Нил эрдэнэ	Amethyst		
17	Оюу	Turquoise		
18	Пироп	Pyrope		



19	Анар	Garnet
20	Саран чулуу	Moonstone
21	Ногоон мана	Chrysoprase
22	Шаргал болор	Citrine
23	Ягаан болор	Rose quartz
Гоёл чимэглэлийн чулуу		
1	Номин	Lapis lazuli
2	Жадеит	Jadeite
3	Хаш	Nephrite
4	Шүр	Coral
5	Усан болор	Rock crystal
6	Утаат болор	Smoky quartz
7	Чароит	Charoite
8	Мана, гартаам	Agate
9	Амазонит	Amazonite
10	Хув	Amber
11	Хар мана	Onyx
12	Үүрийн туяа	Rhodonite
13	Гематит	Hematite
14	Галт уулын шил	Obsidan
15	Ундрам	Aventurine
16	Барын нүд	Tiger's eye
17	Муурын нүд	Cat's eye
18	Шонхорын нүд	Hawk's eye
19	Танзанит	Tanzanite
20	Ногоолин	Malachite
21	Родохрозит	Rhodochrosite
Өнгөлгөөний чулуу		
1	Хас	Jasper
2	Боржин	Granite
3	Чулуужсан мод	Fossilized wood
4	Гантиг	Marble
5	Байгалийн шил	Moldavite
6	Хайлуур жонш	Fluorite
7	Баргилт	Agalmatolite

Тайлбар: Жагсаалтад нэр дурдагдаагүй чулууг ижил шинж чанартай чулууны адилаар тооцно.

Засгийн газрын 2024 оны 05 дугаар
сарын 01-ний өдрийн 181 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ЭРДЭНИЙН ЧУЛУУНЫ СОРЬЦ, ЧАНАРЫГ ТОГТООХ, БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлд сорьц тогтоох шинжилгээ хийх, баталгаажуулах, эрдэнийн чулууг тодорхойлж гэрчилгээ олгох, үнэт металл хайлж гулдмайлах, тэдгээрийг бүртгэх болон энэ үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлд сорьц тогтоох шинжилгээ хийх, баталгаажуулах, эрдэнийн чулууг тодорхойлж гэрчилгээ олгох, үнэт металлыг хайлж гулдмайлах ажлыг сорьцын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллага” гэх), сорьц тогтоох шинжилгээ хийх эрх бүхий итгэмжлэгдсэн хуулийн этгээд гүйцэтгэнэ.

1.3.Энэ журмын 1.2-т заасан байгууллагуудын Үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох лабораториуд нь Үндэсний итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн байна.

1.4.Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулагдаж байгаа сорьцын баталгааны тэмдэг бүхий, үйлдвэрлэгчийн барааны болон тухайн улсын сорьцын баталгааны тэмдэгтэй, эсхүл Олон улсын сорьцын байгууллагуудын холбоо (IAAO)-ны гишүүн орны сорьцын баталгааны тэмдэг бүхий эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлээс бусад импортын эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэл нь сорьцын баталгаагүйд тооцогдоно.

1.5.Сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн сорьцын баталгаатай импортын эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлд гаалийн бүрдүүлэлт хийнэ.

1.6.Сорьцын баталгаагүй импортын эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийг гаалийн байгууллагын албан тушаалтны хяналтад сорьцын баталгаажуулалт хийлгэсний дараа гаалийн бүрдүүлэлт хийнэ.

**Хоёр.Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлээс дээж авах,
сорьц тогтоох шинжилгээ хийх, баталгаажуулах, дээжийн
үлдэгдлийг хадгалах, буцаан олгох**



2.1.Эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлээс дээж авах, сорьц тогтоох шинжилгээ хийх, эрдэнэсийг баталгаажуулах, дээжийн үлдэгдлийг буцаан олгох үйл ажиллагааг энэ журмын 1.2-т заасан байгууллагуудын лабораторид хийж гүйцэтгэнэ. Лаборатори нь сорьц тогтоох шинжилгээний дүнг сорилтын үр дүнгийн хуудсаар баталгаажуулна.

2.2.Сорилтын үр дүнг Монголбанк, арилжааны банкуудад цахимаар илгээж болно. Шинжилгээнд дээж авсан, дээжийн үлдэгдлийг буцаан олгосон, шинжилгээ хийж баталгаажуулсан тухай мэдээллийн санд бүртгэж, бүртгэл хөтөлнө.

2.3.Сорьц тогтоох шинжилгээний дээжийг эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийн үндсэн хайлшийг төлөөлж чадах хэсгээс дараах байдлаар авна:

2.3.1.үнэт металлын гулдмай болон томоохон цул эдлэлээс өрөмдөж, хөндий болон нарийн хийцтэй эдлэлийн бүрдэл болох жижиг хэсгээс, задгай утасны хоёр үзүүрээс, ороолттой утасны задгай талын үзүүрээс хоорондоо 1 метр зайтай хэсгээс, дэвтэрлэсэн хуудас үнэт металлын аль нэг хуудаснаас, хэт жижиг бутархай, нунтаг байдалтай бол хэсгүүдийг нэгтгэн хайлуулсны дараа тус тус тасалж дээж;

2.3.2.10000 граммаас дээш жинтэй гулдмайн дээд болон доод талын хоёр өнцгийн диагоналийн уртын дөрөвний нэгтэй тэнцэх хэсгээс цутгамлын зузааны хоёрны нэг хүртэл гүн өрөмдөж, цутгамлын дээд болон доод талаас солбиж тус бүр хоёр дээж;

2.3.3.100-10000 грамм хүртэл жинтэй гулдмайн дээд доод талын хоёр булангийн диагоналийн уртын дөрөвний нэгтэй тэнцэх хэсгээс гулдмайн зузааны хоёрны нэг хүртэл гүн өрөмдөж цутгамлын дээд, доод талаас солбиж тус бүр нэг дээж;

2.3.4.100 грамм хүртэл жинтэй гулдмай, цутгамал буюу бүхэл хэсгийн голд нь өрөмдөж нэг дээж;

2.3.5.түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлд сорьц тогтоох шинжилгээг өмчлөгчийн зөвшөөрлөөр түүний далд хэсгээс эх төрх, бүрэн бүтэн байдалд нөлөөлөхгүй байдлаар дээж.

2.4.Сорьц тогтоох химийн шинжилгээг Үндэсний итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдсэн сорилт туршилтын лабораторид итгэмжлэлийн хүрэн дэх батлагдсан аргаар, үндэсний болон байгууллагын стандартын дагуу хийнэ.

2.5.Дотоодын үйлдвэрлэгчдийн эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьц тогтоох шинжилгээнд хамруулж баталгаажуулна. Тухайн эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлд эрх бүхий байгууллагаас олгосон үйлдвэрлэгчийн барааны тэмдэг дарагдсан байна.

2.6.Хүн, хуулийн этгээдээс сорьц тогтоолгохоор ирүүлсэн гулдмай бүрд, үнэт металлаар хийсэн эдлэлийн нэг төрлийн 100 ширхэг тутмаас 1 ширхэгт, нэг төрлийн эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэл нь 100 ширхэгт хүрэхгүй байвал 1 ширхэгт тус тус химийн шинжилгээ хийнэ. Химийн шинжилгээнд хамрагдаагүй үлдсэн эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийг багажит шинжилгээнд хамруулна. Багажит шинжилгээний үр дүн нь химийн шинжилгээний үр дүнгээс зөрүүтэй гарсан тохиолдолд эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийг дахин ялгаж химийн шинжилгээнд хамруулж, баталгаажуулна.

2.7.Сорьц тогтоох химийн шинжилгээний үр дүнг үндэслэн эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлд сорьцын баталгааны тэмдгийг дарж баталгаажуулна.

2.8.Сорьцын баталгааны тэмдгийг 2 жил тутамд шинэчлэн зохих нууцлал бүхий өөрчлөлт оруулна.

2.9.Үнэт металлаар хийсэн эдлэлийн сорьцын зөрүү 2-оос илүүгүй байна. Тухайн эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийн шинжилгээний үр дүн стандарт (ISO 9202)-д заасан тохирох сорьцод хүрэхгүй тохиолдолд дараах арга хэмжээг авна:

2.9.1.үйлдвэрлэгч, импортлогч хүсвэл тухайн сорьцод хамгийн ойр байгаа бага сорьцоор баталгаажуулах, эсхүл битүүмжлэн үл борлуулах нөхцөлтэйгөөр буцаана;

2.9.2.тохирох сорьцод хүрэхгүйгээс гадна стандартын шаардлага хангаагүй, Оюуны өмчийн хууль тогтоомж зөрчсөн, бусдын үйлдвэрлэгчийн барааны тэмдгийг дарсан зэрэг тохиолдолд дахин ашиглах боломжгүй болгоно.

2.10.Монголбанкны Эрдэнэсийн санд тушаах алт, мөнгөн гулдмайн сорьц тогтоох шинжилгээний дээжийн үлдэгдлийг энэ журмын 2.1-д заасан эрх бүхий байгууллагын сорьц тогтоох лабораторид битүүмжлэн лацдаж, зориулалтын нөхцөлд түр хугацаагаар хадгална. Эрдэнэсийг битүүмжлэх, түүний дээжийг хадгалах, буцаан олгох журмыг сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллага баталж, хэрэгжүүлнэ.



2.11.Эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийн шинжилгээнд авсан дээжийн үлдэгдлийг сорилтын үр дүнгийн хуудасны хамт хуулийн этгээд, иргэнд буцаан олгоно.

Гурав.Эрдэнийн чулууг тодорхойлох

3.1.Эрдэнийн чулууг олборлогч, эрдэнэсийн эдлэл үйлдвэрлэгч, арилжаалагч иргэн, хуулийн этгээд нь энэ журмын 1.2-т заасан байгууллагуудаар эрдэнийн чулууг тодорхойлуулж, энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан “Эрдэнийн чулууны гэрчилгээ” авна.

3.2.Эрдэнийн чулуун эдлэл эзэмшигч хүсвэл өөрийн эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлд эрдэнийн чулууны гэрчилгээ авч болно.

3.3.Нэг төрлийн их хэмжээтэй таримал (synthetic), хиймэл, дуураймал (imitations) чулуу, чулуун шигтгээг хуулийн этгээд, иргэний хүсэлтийн дагуу тодорхойлох тохиолдолд тухайн чулууны засалтын хэлбэр, хэмжээгээр нь төрөлжүүлэн ялгаж, тэдгээрээс төлөөлүүлэн дээж авч тодорхойлон шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагч дүгнэлт гаргана.

3.4.Гэрчилгээг олгохдоо эрдэнийн чулууны шинжээч цахим мэдээллийн санд бүртгэж, бүртгэлийн дугаар бүхий үнэт цаасан дээр хэвлэн өгнө.

3.5.Эрдэнийн чулууны гэрчилгээний үнэн зөв болохыг уг чулуу, эдлэлийг тодорхойлсон шинжээч, лаборатори хариуцна.

3.6.Эрдэнийн чулууны гэрчилгээ нь зөвхөн тухайн үед тодорхойлуулсан чулуу, чулуун эдлэлийн хувьд хүчинтэй байх бөгөөд уг гэрчилгээг өөр чулуу, эдлэлд ашиглахыг хориглоно.

3.7.Дотоодын гоёл чимэглэлийн үйлдвэр нь эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлд суулгах шигтгээг эдлэлд суулгахаас өмнө тодорхойлуулна.

Дөрөв.Үнэт металлыг хайлж гулдмайлах

4.1.Монголбанкны Эрдэнэсийн санд тушаах үнэт металлыг энэ журмын 1.2-т заасан байгууллагууд хайлж гулдмайлна. Гулдмайн хэмжээ 12.5 кг-аас илүүгүй байна.

4.2.Үнэт металл хайлсан байгууллага энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан “Үнэт металл хайлсан тухай акт” үйлдэж, тухайн иргэн, хуулийн этгээдийн гулдмайн дугаарыг гулдмай тус бүрийн баруун дээд буланд тэмдэглэнэ.



Тав.Эрдэнэсийн бүртгэл

5.1.Үнэт металл олборлогч хуулийн этгээд нь олборлосон үнэт металлын мэдээг энэ журмын 3 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу бүртгэл хөтөлнө.

5.2.Хуулийн этгээд нь үнэт металл олборлолтын тухайн жилийн тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу гаргаж, Үнэт металл олборлолтын бүртгэлийн хамт дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагаар хянуулж, баталгаажуулна.

Зургаа.Ажил, үйлчилгээг цахимжуулах

6.1.Үнэт металлын сорьц тогтоосон сорилтын үр дүнг Монголбанк болон арилжааны банкуудад илгээх, мэдээллийн сан ажиллуулах, ажил үйлчилгээний захиалга, дарааллыг хүлээн авах, бүртгэх зэрэг ажил, үйлчилгээг цахимжуулж, цахимаар үзүүлж болно.

Долоо.Бусад зүйл

7.1.Сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагын улсын байцаагч, шинжээч, ажилтан үүрэгт ажлаа буруу хийсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

7.2.Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, иргэдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сорьцын хяналтын улсын байцаагч хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----



Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг
тогтоох, бүртгэх журмын 1 дүгээр хавсралт

ЭРДЭНИЙН ЧУЛУУНЫ ГЭРЧИЛГЭЭ
Certificate of gemstone

Тодорхойлсон үр дүн
Identification results

Хэлбэр
Shape

Өнгө
Color


Засалт
Cut

Хэмжээ
Dimension

Жин
Mass

Тэмдэглэл
Remarks

Огноо.....



/Эрдэнийн чулууны шинжээчийн
нэр, гарын үсэг, тэмдэг/



Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг
тогтоох, бүртгэх журмын 2 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ ХАЙЛСАН ТУХАЙ АКТ № ...

/Байгууллагын нэр/

/Үнэт металл хайлсан газар/

Огноо:

№	Үнэт металлын нэр	Хайлалтын өмнөх жин	Хайлалтын дараах жин	Хайлалтаас эргүүлж авсан шаар (шлак)-ын жин	Хайлалтын хорогдол	Тайлбар
1	2	3	4	5	6	7

Тайлбар: Гулдмай тус бүр дээр хайлалтын дугаар тавина.

Үнэт металл хайлагч: -----

Үнэт металл хайлахад байлцсан иргэн,
хуулийн этгээдийн төлөөлөл: -----

Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоох, бүртгэх журмын 3 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ ОЛБОРЛОЛТЫН ЖУРНАЛ

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:
Үнэт металл олборлосон аймаг, сум, ордын нэр:
Лицензийн дугаар:

(жин граммаар)

№	Он, сар, өдөр	Угаах төхөөрөмжийн нэр	Металлтай элсний хэмжээ (хүдрийн хэмжээ)	Анхны угаалгын дараах металлын жин	Анхны боловсруулалт хийсний дараах		Өссөн дүнгээр металлын жин	Комиссын гишүүдийн гарын үсэг
					Металлын жин	Хар шлэхийн жин		

Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоох, бүртгэх журмын 4 дүгээр хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ ОЛБОРЛОЛТЫН ЖИЛИЙН ТАЙЛАН

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

Регистрийн дугаар:

Огноо:

(жин граммаар)

№	Олборлолт				Боловсруулалт					Лабораторийн шинжилгээ		Үлдэгдэл					
	Олборлосон хугацаа ... сарын ... өдөр	Угаалгын дараах жин (хүдрийн хэмжээ)	Үнээс ялгасан хар шлэхийн жин	Комиссын актаар хүлээн авсан жин	Металл хайлсан байгууллагын нэр	Хайлалтын дараах гүлдмэйн тоо	Хайлалтын өмнөх жин	Хайлалтын дараах жин	Хайлалтын хортлол	Тогтоосон сорьцын	Тогтоосон сорьцын металлын жин	Эрдэнийн санд, худалдсан он, сар, өдөр	Гүлдмэйн хувийн дугаар	Бохир жин	999,9 сорьцод шилжүүлсэн тооцсон жин		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

Тайлан гаргасан:

Байгууллагын дарга, захирал
 Ерөнхий нягтлан бодогч
 Үнэт металл хүлээн авах комисс

Тайланг хүлээн авсан:

Дарга
 Тамга
 Улсын байцаагч



1	Хөнгөл /Хөнгөл	Rock crystal	
2	Сүлжээ	Coral	
3	Нэрийн хөнгөл	Nephrite	
4	Хөнгөл	Jadete	
5	Хөнгөл	Lapis lazuli	
Хөнгөл /Хөнгөл			
6	Хөнгөл /Хөнгөл	Rose quartz	
7	Хөнгөл /Хөнгөл	Citrine	
8	Хөнгөл /Хөнгөл	Chrysoprase	
9	Хөнгөл /Хөнгөл	Moonstone	
10	Хөнгөл	Garnet	
11	Хөнгөл	Pyrope	
12	Хөнгөл	Turquoise	
13	Хөнгөл	Amethyst	
14	Хөнгөл	Kunzite	
15	Хөнгөл	Beryl	
16	Хөнгөл	Zircon	
17	Хөнгөл	Peridot	
18	Хөнгөл	Tourmaline	
19	Хөнгөл	Rhodolite	
20	Хөнгөл	Topaz	
21	Хөнгөл /Хөнгөл	Aquamarine	
22	Хөнгөл /Хөнгөл	Opal	
23	Хөнгөл	Spinel	
24	Хөнгөл	Demantoid	
25	Хөнгөл	Jadete	



..Зандсануудыг өөр өөрсөнтэйгээ харгалзан үзвэл дараах бичлэгт оруулж үзвэл үндэслэл: Үндэслэл

1	Агальт	Agalmatolite
2	Флюорит	Fluorite
3	Молдавит	Moldavite
4	Мәрмәр	Marble
5	Үхэрлэсэн мод	Fossilized wood
6	Гранит	Granite
7	Жаспер	Jasper
Үхэрлэсэн мод		
8	Үхэрлэсэн мод	Rhodochrosite
9	Малахит	Malachite
10	Танзанит	Tanzanite
11	Хөвсгөлийн гүдгэр	Hawk's eye
12	Хөвсгөлийн гүдгэр	Cat's eye
13	Хөвсгөлийн гүдгэр	Tiger's eye
14	Авентурин	Aventurine
15	Обидан	Obsidian
16	Үхэрлэсэн мод	Hematite
17	Үхэрлэсэн мод	Rhodonite
18	Онх	Onyx
19	Амбер	Amber
20	Амазонит	Amazonite
21	Агат	Agate
22	Хароит	Charoite
23	Смокий кварц	Smoky quartz

6.6. Կրթության և մշակույթի նախարարությունը պարզապես չի կարողանում կենտրոնանալ իր ֆունկցիաների վրա, այլ օգտագործում է իր ֆունկցիաները որպես օրենսդրական և կառավարական գործիքներ, որոնք չեն կարողանում ապահովել իրենց նշանակությունը:

Նախարարությունը չի կարողանում կենտրոնանալ իր ֆունկցիաների վրա, այլ օգտագործում է իր ֆունկցիաները որպես օրենսդրական և կառավարական գործիքներ, որոնք չեն կարողանում ապահովել իրենց նշանակությունը:

6.7. Կրթության և մշակույթի նախարարությունը չի կարողանում կենտրոնանալ իր ֆունկցիաների վրա, այլ օգտագործում է իր ֆունկցիաները որպես օրենսդրական և կառավարական գործիքներ, որոնք չեն կարողանում ապահովել իրենց նշանակությունը:

6.8. Կրթության և մշակույթի նախարարությունը չի կարողանում կենտրոնանալ իր ֆունկցիաների վրա, այլ օգտագործում է իր ֆունկցիաները որպես օրենսդրական և կառավարական գործիքներ, որոնք չեն կարողանում ապահովել իրենց նշանակությունը:

6.9. Կրթության և մշակույթի նախարարությունը չի կարողանում կենտրոնանալ իր ֆունկցիաների վրա, այլ օգտագործում է իր ֆունկցիաները որպես օրենսդրական և կառավարական գործիքներ, որոնք չեն կարողանում ապահովել իրենց նշանակությունը:

6.10. Կրթության և մշակույթի նախարարությունը չի կարողանում կենտրոնանալ իր ֆունկցիաների վրա, այլ օգտագործում է իր ֆունկցիաները որպես օրենսդրական և կառավարական գործիքներ, որոնք չեն կարողանում ապահովել իրենց նշանակությունը:

6.11. Կրթության և մշակույթի նախարարությունը չի կարողանում կենտրոնանալ իր ֆունկցիաների վրա, այլ օգտագործում է իր ֆունկցիաները որպես օրենսդրական և կառավարական գործիքներ, որոնք չեն կարողանում ապահովել իրենց նշանակությունը:



Үндэсний Геммологийн Академи /
 /Хятад улсын Геммологийн Академи

Хугацаа:



Remarks

Амжилттай

Mass

грамм

Dimension

мм-ийн

Cut

хатуу

Color

хатуу

Shape

хатуу

Identification results

Амжилттай / Үндэсний Геммологийн Академи

Certificate of gemstone

Хятад улсын Геммологийн Академи

Үндэсний Геммологийн Академи /
 /Хятад улсын Геммологийн Академи



Анхны	2	
Нийслэл Нийслэл / ГЗ	9	
Баян (Хийд) - ГЗ Хийд Хийд Хийд Нийслэл / ГЗ	5	
Баян Анхны Нийслэл / ГЗ	0	
Баян Хийд Нийслэл / ГЗ	8	
Хийд Хийд Нийслэл	6	
№	9	

Нийслэл ГЗ / Хийд / ГЗ / Нийслэл :
Нийслэл Хийд Нийслэл ГЗ / Хийд /

Нийслэл Хийд Нийслэл :
Хийд Нийслэл ..

Анхны : Нийслэл Нийслэл Нийслэл Нийслэл / ГЗ

Нийслэл :

/Нийслэл / ГЗ / Хийд /
.....

/Нийслэл Хийд Нийслэл / Нийслэл /
.....

Нийслэл Хийд Нийслэл / Нийслэл Нийслэл №...

Нийслэл : Нийслэл Нийслэл ГЗ / ГЗ / Нийслэл / Нийслэл /
Нийслэл Хийд : Нийслэл ГЗ / Нийслэл / ГЗ / Нийслэл /



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 38.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан журмын дагуу үзүүлэх дэмжлэгт шаардагдах зардлыг 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2024 оны 05 дугаар
сарын 22-ны өдрийн 222 дугаар
тогтоолын хавсралт

**ГАДААД УЛСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН НАСАН ТУРШИЙН
БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ТӨРӨӨС
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Боловсролын ерөнхий хуулийн 38.9-д заасны дагуу гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхэд болон иргэдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа Боловсролын ерөнхий хуулийн 18.1-д заасан боловсролын сургалтын байгууллага болон мөн хуулийн 14.6-д заасан насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журмын 1.1-д заасан боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллага (цаашид “байгууллага” гэх)-д төрөөс доор дурдсан дэмжлэгийг үзүүлнэ:

1.2.1.сургалтын хэрэглэгдэхүүн, цахим сурах бичиг, гарын авлагаар хангах;

1.2.2.багш, суралцагчдыг цахим сургалтад хамруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах;

1.2.3.сургалтын модуль, платформыг хөгжүүлэх, монгол хэл, түүх, ёс заншил, соёл, үндэсний өв уламжлалын чиглэлээр контент хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

1.2.4.Соёлын тухай хуулийн 28.1-д заасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх.

Хоёр.Тавигдах шаардлага

2.1.Энэ журмын 1.2-т заасан дэмжлэгийг доор дурдсан шаардлагыг хангасан байгууллагад үзүүлнэ:

2.1.1.Монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх, соёл, өв уламжлалын чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулдаг;



2.1.2.Монгол хүний хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг;

2.1.3.боловсрол нөхөн эзэмших сургалт зохион байгуулдаг;

2.1.4.үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод мэдээлдэг;

2.1.5.эрх бүхий байгууллагаас олгосон дүгнэлт бүхий сургалтын хөтөлбөр; сурах бичиг, гарын авлага зэргийг ашигладаг;

2.1.6.сургалтыг багшлах эрхийн гэрчилгээтэй багш зохион байгуулдаг.

Гурав.Удирдлага, зохион байгуулалт

3.1.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж, доор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1.1.гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын холбогдох мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх;

3.1.2.гадаад оронд амьдарч байгаа монгол иргэдийн эх хэл, ёс заншил, бичиг үсгийн боловсрол эзэмшүүлэх сургалтын жишиг хөтөлбөр, шаардлагатай хэрэглэгдэхүүн, цахим сурах бичгээр хангах, багшийг мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад зайн болон цахим хэлбэрээр хамруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.1.3.сургалтын модуль, платформыг хөгжүүлэх, зөвлөн туслах, багш, суралцагчдыг цахим сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх;

3.1.4.монгол хэл, түүх, ёс заншил, соёл, өв уламжлалын чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд бодит дэмжлэг үзүүлэх;

3.1.5.энэ журмыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж, хамтран ажиллах.

3.2.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:



3.2.1.байгууллагад төрөөс үзүүлэх дэмжлэгийг хүлээн авах, хуваарилах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.2.2.боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэхэд холбогдох мэдээллээр хангаж, хамтран ажиллах.

Дөрөв.Бусад

4.1.Байгууллага энэ журмын 1.2-т заасан дэмжлэгийн хэрэгжилт, түүнтэй холбогдох үйл ажиллагааны тайланг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлнэ.

4.2.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхэд болон иргэнд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай хэвлэмэл сурах бичиг, гарын авлага болон хэрэглэгдэхүүн авах хүсэлт гаргасан тохиолдолд тээвэр, гаалийн болон бусад татварыг гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй тухайн байгууллага хариуцна.

4.3.Боловсролын ерөнхий хуулийн 18.6-д зааснаар байгууллага шашны сургалт, зан үйл, холбогдох бусад үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

---oOo---

Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд

2025 оны 10 сарын 10-ны өдөр /2025.10.10/

Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд

1. Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд

1.1. Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд нь хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмуудыг зөвхөн хэрэглэнэ.

1.2. Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд нь хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмуудыг зөвхөн хэрэглэнэ. Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд нь хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмуудыг зөвхөн хэрэглэнэ.

1.3. Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд нь хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмуудыг зөвхөн хэрэглэнэ. Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд нь хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмуудыг зөвхөн хэрэглэнэ.

Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд

1. Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд

Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд

2. Хувьцаа, хөрөнгийн захирлын тухай хуулийн зарчмууд

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 6

Индекс: 200003